


# ТАЙЛАН

## “ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ” ГЭРЭЭТ АЖИЛ

(Энэ тайланд Кластер-1: Түргэн уулын ДЦГ, Кластер-2: Булган гол, Их Онгогийн БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ, Кластер-3: Хан Хөхийн нурууны БЦГ, Кластер-4: Цамбагарав уулын БЦГ-н хэсэгчилсэн талбай хамаарна.)



**Захиалагч:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам

**Гүйцэтгэгч:** Ой модны сургалт, судалгааны хүрээлэн

Улаанбаатар хот

2021 он

## АГУУЛГА

### ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛБАР

### ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

### ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

### ТАНИЛЦУУЛГА

### ЕРӨНХИЙ ХЭСЭГ

#### 1. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- 1.1. Кластер-I: Түргэн уулын ДЦГ
- 1.2. Кластер-II: Булган гол - Их Онгогийн БЦГ  
Мөнххайрхан уулын БЦГ
- 1.3. Кластер-III: Хан Хөхий нурууны БЦГ
- 1.4. Кластер-IV. Цамбагарав уулын БЦГ

#### 2. КЛАСТЕР НУТГИЙН ОЙН САНГИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ

- 2.1. Кластер-I: Түргэн уулын ДЦГ-ын ойн сангийн суурь үзүүлэлт
- 2.2. Кластер-II: Булган гол-Их Онгогийн БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ-ын ойн сангийн суурь үзүүлэлт
- 2.3. Кластер-III: Хан Хөхий нурууны БЦГ-ын ойн сангийн суурь үзүүлэлт
- 2.4. Кластер-IV: Цамбагарав уулын БЦГ-ын ойн сангийн суурь үзүүлэлт

#### 3. КЛАСТЕР НУТАГ ТУС БҮРИЙН ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ

- 3.1. Тусгай хамгаалалттай нутгуудад хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээ
- 3.2. Хяналт-мониторингийн цэг
- 3.3. Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ

#### 4. КЛАСТЕР НУТАГ ТУС БҮРИЙН ОЙН БҮРХЭВЧИЙН ЗУРАГ БОЛОН НЭН ХОВОР, ХОВОР, УНАГАН УРГАМЛЫН ТАРХАЛТЫН ЗУРАГЛАЛ

- 4.1. Кластер-I Түргэн уулын ДЦГ-ын ойн бүрхэвчийн зураг
  - 4.1.1 Түргэн уулын ДЦГ-ын ойн төлөв байдлын зураг
  - 4.1.2. Түргэн уулын ДЦГ-ын ойн тархалтын зураг
  - 4.1.3. Түргэн уулын ДЦГ-ын ойн арга хэмжээний зураг
- 4.2. Кластер-II Булган гол, Их Онгогийн БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ-ын ойн бүрхэвчийн зураг
  - 4.2.1 Ойн тархалтын зураг (Булган гол-Их Онгогийн БЦГ)
  - 4.2.2. Ойн тархалтын зураг (Мөнххайрхан уулын БЦГ)
  - 4.2.3. Ховор ургамлын байршил (Булган гол-Их Онгогийн БЦГ)
  - 4.2.4. Ойн төлөв байдлын зураг (Мөнххайрхан уулын БЦГ)

- 4.3. Кластер-III Хан Хөхий нурууны БЦГ-ын ойн бүрхэвчийн зураг
  - 4.3.1 Ойн тархалтын зураг (Хан Хөхий нурууны БЦГ)
  - 4.3.2. Ойн төлөв байдлын зураг (Хан Хөхий нурууны БЦГ)
  - 4.3.3. Ойн арга хэмжээний төлөвлөлтийн зураг (Хан Хөхий нурууны БЦГ)
- 4.4. Кластер-IV Цамбагарав уулын БЦГ-ын ойн бүрхэвчийн зураг
  - 4.4.1. Нэн ховор, ховор, унаган ургамалын тархалтын зураглал

## **5. КЛАСТЕР НУТГИЙН ТХГН-ИЙН ОРЧНЫ БҮСИЙН СУМУУДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

- 5.1. Кластер-I бүс нутгийн ТХГН-ийн орчны бүсийн сумуудын ерөнхий мэдээлэл
  - 5.1.1 Увс аймгийн Түргэн сумын нийгэм, эдийн засгийн талаар ерөнхий мэдээлэл
  - 5.1.2. Ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын төлөв байдлын судалгаа
  - 5.1.3 SWOT дүн шинжилгээ
  - 5.1.4 Кластер-I бүс нутгийн ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг ашиглах зөвлөмж
- 5.2. Кластер-II бүс нутгийн ТХГН-ийн орчны бүсийн сумуудын ерөнхий мэдээлэл
  - 5.2.1. Ховд аймгийн Булган сум, Баян-Өлгий аймгийн Булган сумын нийгэм, эдийн засгийн талаар ерөнхий мэдээлэл
  - 5.2.2. Ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын төлөв байдлын судалгаа
  - 5.2.3 SWOT дүн шинжилгээ
  - 5.2.4 Кластер-II бүс нутгийн ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг ашиглах зөвлөмж
- 5.3. Кластер-III бүс нутгийн ТХГН-ийн орчны бүсийн сумуудын ерөнхий мэдээлэл
  - 5.3.1. Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумдын нийгэм, эдийн засгийн талаар ерөнхий мэдээлэл
  - 5.3.2. Ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын төлөв байдлын судалгаа
  - 5.3.3 SWOT дүн шинжилгээ
  - 5.3.4. Кластер-III бүс нутгийн ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг ашиглах зөвлөмж
- 5.4. Кластер-IV бүс нутгийн ТХГН-ийн орчны бүсийн сумуудын ерөнхий мэдээлэл
  - 5.4.1. Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн сумын нийгэм, эдийн засгийн талаар ерөнхий мэдээлэл
  - 5.4.2. Ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын төлөв байдалын судалгаа
  - 5.4.3 SWOT дүн шинжилгээ
  - 5.4.4. Кластер-IV бүс нутгийн ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг

ашиглах зөвлөмж

**6. ДҮГНЭЛТ**

**7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

**8. ХАВСРАЛТ**

Хавсралт 1. Ажлын даалгавар

Хавсралт 2. Санал асуулгын хуудсууд

Хавсралт 3. Судалгаанд санал өгсөн оролцогчдын нэр

## **ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛБАР**

ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ДЦГ	Дархан цаазат газар
БЦГ	Байгалийн цогцолборт газар
SWOT	Давуу тал, Сул тал, Боломж, Аюул занал
БОЯБХУАӨДЗ	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
ОН	Ойн нөхөрлөл
ОМБ	Ойн мэргэжлийн байгууллага
БСУ	Байгалийн сэргэн ургалт
БОАЖЯ	Байгаь орчин, аялал жуулчиллын яам
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

- Хүснэгт 1. Судалгаанд хамрагдах газар, нутаг
- Хүснэгт 2. Кластер – I Судалгаанд хамрагдах газар, нутаг
- Хүснэгт 3. Кластер – II. Судалгаанд хамрагдах газар, нутаг
- Хүснэгт 4. Кластер – III. судалгаанд хамрагдах газар, нутаг
- Хүснэгт 5. Кластер – IV. судалгаанд хамрагдах газар, нутаг
- Хүснэгт 6. Судалгаанд ашигласан ой зохион байгуулалтын мэдээ
- Хүснэгт 7. Кластер – I. Ойн сангийн талбайн дүнгийн хүснэгт /газрын төрлийн ангилалаар/ /талбай-га/
- Хүснэгт 8. Ойн сангийн талбай, бүсийн төрлөөр
- Хүснэгт 9. Ойн нөөцийн дүнгийн хүснэгт
- Хүснэгт 10. Ойг бүрдүүлэгч модны төрөл
- Хүснэгт 11. Таксацын дундаж үзүүлэлтүүд
- Хүснэгт 12. Ойн талбай, нөөцийн насны ангийн хүснэгт
- Хүснэгт 13. Ойн талбай, нөөцийн насны бүлэг
- Хүснэгт 14. Ойн талбайн бонитетийн ангийн хүснэгт
- Хүснэгт 15. Ойн талбайн өтгөрлийн хүснэгт
- Хүснэгт 16. Кластер – II. Ойн сан бүхий газрын талбайн төрөл /талбай-га/
- Хүснэгт 17. Ойн нөөцийн дүнгийн хүснэгт
- Хүснэгт 18. Таксацын дундаж үзүүлэлтүүд
- Хүснэгт 19. Ойн талбай, нөөцийн насны ангийн хүснэгт
- Хүснэгт 20. Ойн талбай, нөөцийн насны бүлгийн хүснэгт
- Хүснэгт 21. Ойн талбайн бонитетийн ангийн хүснэгт
- Хүснэгт 22. Ойн талбайн өтгөрлийн хүснэгт
- Хүснэгт 23. Кластер – III. Ойн сангийн талбайн дүнгийн хүснэгт /газрын төрлийн ангилалаар/ /талбай-га/
- Хүснэгт 24. Ойн сангийн талбай, бүсийн төрлөөр
- Хүснэгт 25. Ойн нөөцийн дүнгийн хүснэгт
- Хүснэгт 26. Ойг бүрдүүлэгч модны төрөл
- Хүснэгт 27. Таксацын дундаж үзүүлэлтүүд
- Хүснэгт 28. Ойн талбай, нөөцийн насны ангийн хүснэгт
- Хүснэгт 29. Ойн талбай, нөөцийн насны бүлгийн хүснэгт
- Хүснэгт 30. Ойн талбайн бонитетийн ангийн хүснэгт
- Хүснэгт 31. Ойн талбайн өтгөрлийн хүснэгт
- Хүснэгт 32. Ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлт
- Хүснэгт 33. Ойн аж ахуйн арга хэмжээ
- Хүснэгт 34. Хяналтаар авсан болон сонгосон цэгийн үзүүлэлт

- Хүснэгт 35. Ойн экологи-Эдийн засгийн үнэлгээ
- Хүснэгт 36. Түргэн Сумын хүн ам болон малын тоо
- Хүснэгт 37. Кластер-I: ойн аж ахуйн арга хэмжээ
- Хүснэгт 38. Кластер-I: Ойгоос олж байгаа орлого
- Хүснэгт 39. SWOT шинжилгээ
- Хүснэгт 40. Кластер-I: Хэрэгжүүлэх төслийн санал
- Хүснэгт 41. Сумын хүн ам болон малын тоо
- Хүснэгт 42. Класер-II: ойн аж ахуйн арга хэмжээ
- Хүснэгт 43. Ойгоос олж байгаа орлого
- Хүснэгт 44. SWOT шинжилгээ
- Хүснэгт 45. Хэрэгжүүлэх төслийн санал
- Хүснэгт 46. Кластер – III. Сумын хүн ам болон малын тоо
- Хүснэгт 47. Кластер – III. ойн аж ахуйн арга хэмжээ
- Хүснэгт 48. Ойгоос олж байгаа орлого
- Хүснэгт 49. SWOT шинжилгээ
- Хүснэгт 50. Хэрэгжүүлэх төслийн санал
- Хүснэгт 51. Кластер – IV. Сумдын хүн ам болон малын тоо
- Хүснэгт 52. Класер-IV: ойн аж ахуйн арга хэмжээ
- Хүснэгт 53. Ойгоос олж байгаа орлого
- Хүснэгт 54. SWOT шинжилгээ
- Хүснэгт 55. Хэрэгжүүлэх төлсийн санал

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

- Зураг 1. Кластер I. Түргэн уулын ДЦГ
- Зураг 2. Кластер- I: Судалгаанд хамрагдсан газар, нутаг
- Зураг 3. Кластер II. Булган гол-Их Онгогийн БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ
- Зураг 4. Кластер- II: Судалгаанд хамрагдсан газар, нутаг
- Зураг 5. Кластер- III: Хан Хөхий нурууны БЦГ
- Зураг 6. Кластер- III: Судалгаанд хамрагдсан газар, нутаг
- Зураг 7. Кластер- IV: Цамбагарав уулын БЦГ
- Зураг 8. Кластер- IV: Судалгаанд хамрагдсан газар, нутаг
- Зураг 9. Кластер I. Ойн сан бүхий газрын талбайн төрөл
- Зураг 10. Ойн сангийн талбайн газрын төрлийн эзлэх хувь
- Зураг 11. Ойн нөөцийн налуугийн бүлгийн ангилал
- Зураг 12. Насны ангийн тархалт
- Зураг 13. Насны бүлэг
- Зураг 14. Ойн өтгөрөл
- Зураг 15. Кластер – II. Ойн сангийн талбайн газрын төрлийн эзлэх хувь
- Зураг 16. Ойн нөөцийн налуугийн бүлгийн ангилал
- Зураг 17. Насны ангийн тархалт
- Зураг 18. Насны бүлэг
- Зураг 19. Ойн өтгөрөл
- Зураг 20. Кластер- III: Ойн сан бүхий газрын талбайн төрөл
- Зураг 21. Ойн сангийн талбайн газрын төрлийн эзлэх хувь
- Зураг 22. Ойн нөөцийн налуугийн бүлгийн ангилал
- Зураг 23. Насны ангийн тархалт
- Зураг 24. Насны бүлэг
- Зураг 25. Ойн өтгөрөл
- Зураг 26. Түргэн уулын ДЦГ: Ойн тархалт
- Зураг 27. Түргэн уулын ДЦГ: Ойн төлөв байдал
- Зураг 28. Түргэн уулын ДЦГ: Ойн арга хэмжээний төлөвлөлт
- Зураг 29. Ойн тархалтын зураг (Булган гол-Их Онгогийн БЦГ)
- Зураг 30. Ойн тархалтын зураг (Мөнххайрхан уулын БЦГ)
- Зураг 31. Ховор ургамлын байршил болон суурьшлын бүс (Булган гол-Их Онгогийн БЦГ)
- Зураг 32. Ойн төлөв байдлын зураг (Мөнххайрхан уулын БЦГ)
- Зураг 33. Ойн тархалтын зураг (Хан Хөхий нурууны БЦГ)
- Зураг 34. Ойн төлөв байдлын зураг (Хан Хөхий нурууны БЦГ)
- Зураг 35. Ойн арга хэмжээний төлөвлөлтийн зураг (Хан Хөхий нурууны БЦГ)



- Зураг 36. Нэн ховор, ховор, унаган ургамлын тархалтын зураглал
- Зураг 37. Түргэн сумын оролцогч талуудтай хийсэн уулзалт
- Зураг 38. Оролцооны аргаар зурагласан зураг
- Зураг 39. Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Булган сумын оролцогч талуудтай хийсэн уулзалт
- Зураг 40. Оролцооны аргаар зурагласан зураг
- Зураг 41. Шигүү ургасан залуу ой болон ойн захгаар тэлж ургаж байгаа зулзган модыг мал идсэн байдал
- Зураг 42. Нарийн шургаагийг байшин барих, хашааны шон хийхэд ашигласан байдал
- Зураг 43. Түлшинд хэрэглэдэг хатсан, унасан мод, мөчир гишүү
- Зураг 44. Таримал жимсний плантаци
- Зураг 45. Оролцооны аргаар зураглал хийж буй байдал
- Зураг 46. Зүсвэрийн хөрөө рамаас гарсан үртэс, зоргодсыг хог дээр хаяхаар ачааны машинд ачсан байдал
- Зураг 47. Ховд аймгийн Мянгад,Эрдэнэбүрэн сумын оролцогч талуудтай хийсэн уулзалт
- Зураг 48. Оролцоогы аргаар зураглуулсан зураг
- Зураг 49. Ойн бус материалаар барьсан хашаа
- Зураг 50. Бургасаар хийсэн гэрийн мод
- Зураг 51. Гадны аймаг, сумдаас худалдаж авдаг модон хавтангаар хийсэн тавилга

## ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

<p style="text-align: center; color: blue; font-weight: bold;">СУДАЛГААНЫ ЗОРИЛГО</p> <p>“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” (БОЯБХУАӨДЗ) төслийн Монгол орны баруун болон баруун өмнөд бүсэд газар зүйн томоохон бүс нутаг болох кластерын түвшинд, кластерт хамрагдах ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүсүүд болон экологийн холбоос нутгуудыг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс, экологийн холбоос нутагт амьдардаг нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгын хүрээнд төсөлд хамрагдах ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүсийн ойн сан, ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлоход оршино.</p>	<p style="text-align: center; color: blue; font-weight: bold;">СУДАЛГААНЫ ЗОРИЛТ</p> <p><b>Зорилт-1.</b> БОЯБХУАӨДЗ төслийн 1, 2, 3, 4-р Кластераас сонгогдсон тусгай хамгаалалттай газруудын ойн сангийн суурь үзүүлэлтийг тодорхойлох;</p> <p><b>Зорилт-2.</b> Кластер бүс нутгийн ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтийг тодорхойлох;</p> <p><b>Зорилт-3.</b> Ойн бүрхэвчийн зураг болон нэн ховор, ховор, унаган ургамалын тархалтын зураглал, хамгаалах зөвлөмж боловсруулах;</p> <p><b>Зорилт-4.</b> Кластерийн ой ашиглалтын төлөв байдалтай уялдуулж нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор тухайн бүс нутгийн ойн сангийн нөөц, өнөөгийн төлөв байдалд тулгуурлан ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг ашиглан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр зөвлөмж боловсруулах;</p>
---	---

### СУДАЛГААНД ХАМРАГДАХ ГАЗАР, НУТАГ

Кластер	Аймаг	№	Сумын нэр	ТХГН-ын нэр
Кластер-I	Увс	1	Түргэн	Түргэн уулын ДЦГ
Кластер-II	Ховд	2	Булган	Булган гол, Их Онгогийн БЦГ
	Баян-Өлгий	3	Булган	Мөнххайрхан уулын БЦГ
Кластер-III	Увс	4	Өндөрхангай	Хан Хөхий нурууны БЦГ
		5	Зүүнхангай	
		6	Цагаанхайрхан	
Кластер-IV	Ховд	7	Мянгад	Цамбагарав уулын БЦГ
		8	Эрдэнэбүрэн	

### КЛАСТЕРИЙН БҮС НУТГУУДЫН ОЙН САНГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Аймаг, сумын нэр	Ойн сангийн газрын төрөл			Ойн бус талбай	Ойн сангийн нийт талбай
	Ойн талбай				
	Ойгоор бүрхэгдсэн	Ойгоор бүрхэгдээгүй	Дүн		
<b>Кластер – I. Түргэн уулын ДЦГ</b>					
Увс-Түргэн	13687	576	14263	185	14448
<b>Кластер – II. Булган гол Их Онгог БЦГ</b>					
Ховд-Булган	3093	498	3591	-	3591
<b>Мөнххайрхан уулын БЦГ</b>					
Баян-Өлгий Булган	4180	1068	5248	-	5248
Кластерийн дүн	7273	1566	8839	-	8839

Кластер – III. Хан хөхийн нурууны БЦГ					
Увс Өндөрхангай	34445	5342	39787	1068	40855
Зүүнхангай	20970	838	21808	381	22189
Цагаанхайрхан	13913	928	14841	537	15378
Кластерийн дүн	69328	7108	76436	1986	78422
Кластер – IV. Цамбагарав уулын БЦГ					
Ховд Мянгад	Энэ сумаас манай судалгааны талбайд Ховд голын дагуу багахан хэсэг орсон боловч яг энэ хэсэгт голын дагуу шугуй байхгүй. Судалгааны хилийн гадна голын татамд мониторингийн цэг байгуулсан.				
Эрдэнэбүрэн	Эрдэнэбүрэн сумаас судалгааны талбай буюу БЦГ-ын хилд нэлээд хэмжээний талбай ордог боловч ОЗБ-ын судалгаанд хамрагдаагүй байна. Хилийн гадна мониторингийн цэг байгуулсан.				

#### КЛАСТЕРЫН БУС НУТГИЙН ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ

№	Ойн тогтвортой менежментийн шалгуур үзүүлэлт		Кластер бүрийн суурь үзүүлэлт, (2021 оны хэмжээгээр)			
	Шал-гуур	Үзүүлэлт	Кластер-1	Кластер-2	Кластер-3	Кластер-4
1	Ойн экологийн төлөв байдал	Ойн хүлэмжийн хийн ялгарал, tCO <sub>2</sub> e/жил	26142	-	120876	
		Ойн хүлэмжийн шингээлт	37671	24577	193438	
		Ойн өсөлт, га/м3	0.93	0.77	1.03	
		ОН, ОМБ-н эзэмшилд байгаа ойн хэмжээ, га	212		2392	
		Нөхөн сэргээсэн ойн хэмжээ, га	12	-	-	
2	Ойн эдийн үр ашиг засгийн	1 га ойн өгөөж, бүгд, мян₮	62.0	35.0	89.0	
		А. 1 га ойгоос ашиглаж буй дагалт баялгийн хэмжээ, мян₮	3.0	0.7	4.7	
		Б. Түлээний мод, мян₮	5391.9		40264.7	
		В. Ойн аялал, бусад, мян₮	15.0	56.0	21.0	73.0
3	Ойн нийгмийн үр ашиг	Ойгоос амьжиргааны эх үүсвэр авдаг иргэдийн тоо, бүгд, хүн	144		756	
		А. Ойн нөхөрлөлийн гишүүн, хүний тоо	24		126	
		Б. Ойн мэргэжлийн байгууллагад ажилладаг, хүний тоо	-		30	
		В. Бусад, хүний тоо				

**КЛАСТЕРИЙН БҮС НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ НУТГУУДАД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭ**

№	Аж ахуйн арга хэмжээ, га	Бүс нутаг				Нийт дүн, га/м <sup>3</sup>
		Кластер I	Кластер II	Кластер III	Кластер IV	
1	Арчилгааны огтлолт	930	935	2696	-	<b>4561</b>
		21462	13684	45935	-	<b>81081</b>
2	Цэвэрлэгээний огтлолт	33	-	4447	-	<b>4480</b>
		990	-	132053	-	<b>133043</b>
3	Ойжуулалт	195	81	1957	-	<b>2233</b>
4	БСУ туслах		-	1123	-	<b>1123</b>
5	Самар түүх	-	-	1170		<b>1170</b>
6	Жимс түүх	-	-	1199		<b>1199</b>
7	Өндөр хожуулыг тайрах	2750	-	8419	-	<b>11169</b>
		2700	-	8400	-	<b>11100</b>
<b>Кластерийн дүн</b>		<b>3908</b>	<b>1016</b>	<b>21021</b>	-	<b>25945</b>
		<b>25152</b>	<b>13684</b>	<b>186388</b>	-	<b>225224</b>

## ТАНИЛЦУУЛГА

**Судалгааны үндэслэл, шаардлага:** Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Германы Сэргээн Босголтын Зээлийн банкаар дамжуулан БОАЖЯ-тай “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн 2, 3-р үе шатууд 2020 оны 3-р сараас Монгол орны баруун бүсэд хэрэгжиж байна. Тус төслийн зорилго нь Монгол орны баруун болон баруун өмнөд бүсэд газар зүйн томоохон бүс нутаг болох кластерын түвшинд, кластерт хамрагдах ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүсүүд болон экологийн холбоос нутгуудыг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс, экологийн холбоос нутагт амьдардаг нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино. Төслийн “ТХГН болон Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөний дагуу хамгаалалт нь сайжирсан, тогтвортой менежментээр ашиглагдаж байгаа ойн талбай нэмэгдсэн байна” гэсэн шалгуур үзүүлэлт 2-ын дагуу кластер бүс нутгийн ойн сан, ойн менежментийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, төслийн хэрэгжилтийн дүнд ямар эерэг болон сөрөг өөрчлөлт гарахыг үнэлэхэд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх зорилгоор төсөлд хамрагддаг ТХГН-ууд тэдгээрийн орчны бүсийн ойн сан, ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтүүдийг 2020 онд тус бүсэд хийгдсэн ой зохион байгуулалтын тайлан, мэдээллийг үндэслэн тодорхойлов.

**Хамрах хүрээ:** БОЯБХУАӨДЗ төслийн 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 4 кластерт хамрагдах ТХГН, тэдгээрийн орчны бүсийн сумдаас ойн тогтвортой менежментийн төлөөлөх 3 аймгийн нийт 8 сумыг суурь судалгаанд хамруулсан.

**Судалгааны багийн бүрэлдэхүүн:** ШУТИС-ийн Ой модны сургалт, судалгааны хүрээлэнгийн судалгааны багийн ахлагчаар Ц.Банзрагч (Ph.D), судлаачаар Ч.Ганбаатар (Ph.D), Т.Баясаа (Ph.D), Б.Баярсайхан, З.Нарангэрэл нар 4 кластерт хамрагдах ТХГН-ын ойн менежментийн талаарх суурь мэдээллийг бүрдүүлэн, нэмэлт хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэн, нэгтгэн дүгнэж, тус тайланг боловсруулав.

## ЕРӨНХИЙ ХЭСЭГ

**Судалгааны зорилго:** “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” (БОЯБХУАӨДЗ) төслийн Монгол орны баруун болон баруун өмнөд хэсэгт газар зүйн томоохон бүс нутгаар кластер болгон түүнд хамрагдах ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүсүүд болон экологийн холбоос нутгуудыг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс, экологийн холбоос нутагт амьдардаг нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгын хүрээнд төсөлд хамрагдах ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүсийн ойн сан, ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлоход оршино.

### Судалгааны зорилтууд:

Зорилт-1. БОЯБХУАӨДЗ төслийн 1,2,3,4-р Кластераас сонгогдсон тусгай хамгаалалттай газруудын ойн сангийн суурь үзүүлэлтийг тодорхойлох;

Зорилт-2. Кластер бүс нутгийн ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтийг тодорхойлох;

Зорилт-3. Ойн бүрхэвчийн зураг болон нэн ховор, ховор, унаган ургамалын тархалтын зураглал, хамгаалах зөвлөмж боловсруулах;

Зорилт-4. Кластерийн ой ашиглалтын төлөв байдалтай уялдуулж нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор тухайн бүс нутгийн ойн сангийн нөөц, өнөөгийн төлөв байдалд тулгуурлан ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг ашиглан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр зөвлөмж боловсруулах;

**Ойн тогтвортой менежментийн суурь судалгаанд хамрагдсан газрууд:** БОЯБХУАӨДЗ төслийн 1,2,3,4-р кластерт хамрагдах ТХГН, тэдгээрийн орчны бүсийн сумдаас ойн тогтвортой менежментийн төлөөлөл 3 аймгийн нийт 8 сум (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдах газар, нутаг

Кластер	Аймаг	№	Сумын нэр	ТХГН-ын нэр
Кластер-I	Увс	1	Түргэн	Түргэн уулын ДЦГ
Кластер-II	Ховд	2	Булган	Булган гол, Их Онгогийн БЦГ
	Баян-Өлгий	3	Булган	Мөнххайрхан уулын БЦГ
Кластер-III	Увс	4	Өндөрхангай	Хан Хөхий нурууны БЦГ
		5	Зүүнхангай	
		6	Цагаанхайрхан	
Кластер-IV	Ховд	7	Мянгад	Цамбагарав уулын БЦГ
		8	Эрдэнэбүрэн	

## 1. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### 1.1. КЛАСТЕР-I: ТҮРГЭН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР

**Хамгаалалтанд авсан үндэслэл:** Энэхүү газар нутгийг Увс нуурын ай савын дархан цаазат газруудад хамруулан Монгол Улсын Улсын Их Хурлын 1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 83 дугаар тогтоолоор дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч улмаар байгалийн үзэсгэлэнт Гоожуурын хүрхрээ орчмын газар нутгийг хамгаалах зорилгоор Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар тогтоолоор хилийн заагийг өргөтгөсөн. Түргэн уулын ДЦГ нь Увс аймгийн Түргэн, Улаангом, Тариалан, Ховд, Бөхмөрөн сумдын нутаг дэвсгэрт хамаарах нийт **130,473 га** талбайг хамардаг.

Түргэний уулс нь уулын тундр, ой, тайга, уулын хээр, мөнх цас, мөсөн тогоо, мөсөн гол тэдгээрийн усан хүрхрээ, агуй, хад цохио зэрэг байгалийн олон янз байдал, өвөрмөц тогтоц хосолсон байгалийн үзэсгэлэн бүрдсэн газар нутаг юм. Түргэний уул мөнх цас мөсөн голууд элбэгтэй бөгөөд нийтдээ 104 км<sup>2</sup> буюу Монгол орны уулсын мөсдлийн нийт талбайн 20 гаруй хувийг эзэлдэг.




Зураг 1. Кластер I. Түргэн уулын ДЦГ

Түргэний уулсаас Хархираа, Түргэн, Ямаат, Шивэр зэрэг голууд эх авч урсдаг. Түүнчлэн, биологийн олон янз байдлаар нэн баялаг бөгөөд Цоохор ирвэс (*Uncia uncia*), Аргаль хонь (*Ovis ammon*), Янгир ямаа (*Capra sibirica*), Халиун буга (*Gervus elaphus*), Шилүүс мий (*Linnaeus*), Мануул мий (*Otocolobus manul*), Бор гөрөөс (*Capreolos pygargus*), Зэрлэг гахай (*Sus scrofa*), Хадны суусар (*Martes foina*) зэрэг хөхтөн амьтан, ховор шувуудаас Алтайн хойлог (*Tetragallus altaicus*) байдаг. Нөмрөгт банздоо (*Saussurea involucrata*), Ягаан мүгээ (*Grassulaceae*), Том навчит дэгд (*Gentianaceae*), Буржгар сараана (*Liliaceae*), Алтан бэрмэг (*Plumbaginaceae*) зэрэг нэн ховор, Алтайн сонгино (*Allium altaicum*), Сарвуун сонгино (*Allium anisopodium Ledeb*), Шулуун сонгино (*Allium Lineare L*), Азийн төлөгч өвс (*Achille asiatica Seg*), Алтайн далан

хальс (*Lonicera altaica Pall*), Үлдэн могойн идээ (*Sedum aizoon L*) зэрэг ховор ургамлуудтай.

Хүснэгт 2. Кластер – I Судалгаанд хамрагдах газар, нутаг

Кластер	ТХГН-ын нэр	Аймаг	Сумын нэр	ДЦГ-ын талбай га	Сумын эзлэх хувь
Кластер - I	Түргэн уулын ДЦГ	Увс	Түргэн	130473	30,5
Хамгаалалтын захиргаа	Увс нуурын ай савын УТХГН-ийн хамгаалалтын захиргаа				




Зураг 2. Кластер- I: Судалгаанд хамрагдсан газар, нутаг



## 1.2. КЛАСТЕР-II: БУЛГАН ГОЛ - ИХ ОНГОГИЙН БЦГ, МӨНХХАЙРХАН УУЛЫН БЦГ

**Хамгаалалтанд авсан үндэслэл (БУЛГАН ГОЛ - ИХ ОНГОГИЙН БЦГ):** Булган голд амьдардаг үнэт арьстай ховор амьтан болох минжийг хамгаалах зорилгоор Ховд аймгийн Булган сумын нутаг, Булган голын минжтэй хэсэг зурвас газрыг 1965 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 17-р зарлигаар анх улсын хэмжээний дархан цаазат газар болгосон. Булган голын дархан газар нь зөвхөн минжийг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилготой учраас 1995 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор тусгай хамгаалалттай газар нутгийн хуульд нийцүүлэн ховордсон амьтныг хамгаалах зорилго бүхий байгалийн нөөц газар болгосон ба УИХ-ын 2011 оны 18 дугаар тогтоолоор ангилал дээшлүүлэн Их Онгогийн 80 мянган гагаар өргөтгөн Байгалийн цогцолборт газар болгосон байна. УИХ-ын 2019 оны 5 дугаар сарын 02-ны 41 дүгээр тогтоолоор Булган гол-Их Онгогийн газар нутгийг 153,338 га талбайгаар дахин өргөтөл хийсэн. Нийт талбайн хэмжээ 286081 га юм.

Булган гол нь Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Булган сумдын нутгийн дундуур урсаж улмаар улсын хил даван Оронго голд цутгадаг Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах гол юм. Их Онгог нь ховор амьтан ургамал ихтэй, Монгол Алтайн нурууны өвөр хэсэг, Тус нутагт дэлхийд



ховордсон нэн ховор ургамал болох залаархаг хавраг (*Ferula feruloides*) буюу чийр ургадаг. Чийрийн давирхай нь ховор сонин ургамал бөгөөд эмчилгээний ач холбогдолтой нь албан ёсоор батлагдаагүй боловч хүмүүс ихээр түүж ашигладаг байна. Булган голын дагуу Дашванжил уулаас улсын хил хүртэлх өчүүхэн зурваст минжийн уугуул популяци нутаглаж байна. Энэ хамгаалалтад авсан нутгийн амьтны аймаг үлэмж олон янз. Нэн ховор амьтан болох минж, мөнгөн сортой хар булга, хадны цагаан элэгт суусар, замба гүрвэл, цоохор ирвэс гэх мэт амьтад байна. Нөөц


газрын зурваст аргаль, янгир, хулан, хар сүүлт, ирвэс, шилүүс, үнэг чоно, мануул, хадны суусар зэрэг ан амьтад элбэгээс гадна энд хонин гүрвэл, могой гүрвэл, мэлхий, могой зэрэг хэвлээр явагчид байдаг. Булган голд алгана, мөрөг, зоодой зэрэг загас бий. Мөн нүүдлийн болон усны олон төрөл зүйлийн шувуудтай.

**Хамгаалалтанд авсан үндэслэл** (МӨНХХАЙРХАН УУЛЫН БЦГ): Монгол Улсын Их хурлын 2006 оны 26 дугаар тогтоолоор Мөнххайран уул, түүний орчмын газар нутгийн зарим хэсгийг БЦГ-ын ангилалаар улсын тусгай хамгаалалтанд авснаар Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Мөнххайрхан сумдын хил залгаа нутгийг дамнан нийт тайлбай нь 301144.011 га баруунаас зүүн тийш 40-80 км өргөн, хойноос ургаш 200 гаруй км урт үргэлжлэх газар нутаг анх хамрагдсан юм. Мөнххайрхан уул, түүний орчмын онцлох экосистемийг бүхэлд нь хамгаалах зорилгоор Мөнххайрхан уулын өвөр хэсэг Үенчийн хавчал, түүний орчмын зарим хэсгийн 204,950 га талбай бүхий газар нутгийг УИХ-ын 2011 оны 18 дугаар тогтоолоор 191,5 мянган га-гаар өргөтгөн улсын тусгай хамгаалалтанд авснаар цогцолборт газрын нийт талбай 506,095 га, өргөн нь 80-130 км, урт нь 350 км болж өргөжсөн.

Мөнххайрхан уул, Үенчийн хавцал, түүний орчмын газар нутаг хамрагдана. Монгол Алтайн нурууны шим мандлын нөөц газрын томоохон төвүүдийн нэг болох Мөнххайрхан уул түүний орчмын газар нутгийг хамгаалалтад авснаар Даян дэлхийн уур амьсгалын ерөнхий дулаарлын улмаас шим мандалд, ялангуяа Алтайн уулын систем түүний томоохон оргилууд дахь мөнх цас, мөсөн голуудад гарч буй өөрчлөлтийг тогтмол хянан ажиглахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Төв Азийн цөлийн нөлөөнд орших хязгаарлагдмал эмзэг нөхцөлд бүрэлдэн тогтсон мөнх цэвдэг, мөсөн голууд бүхий өндөр уулын өвөрмөц ландшафтыг хамгаалалтад авснаар байгалийн цэнгэг усны асар их нөөцийг олон улсын дэмжлэг оролцоотойгоор хадгалж хамгаалах нөхцөл бүрдэхийн сацуу мөнх цас, мөсөөр тэжээгддэг Алтайн нурууны ар, өвөр хажуугаас их авч урсдаг их бага олон голуудын эхийг хамгаалах, хөрсний чийгийн горимыг тогтвортой байлгахад тусална. Мөнххайрхан-Булган гол орчмын нутагт нийтдээ 61 овгийн 241 төрлийн 690 зүйлийн ургамал байдгаас 98 зүйл нь мод сөөг, 592 зүйл нь өвслөг ургамал юм. Дэлхийн болоод монголын ховор амьтдын бүртгэлд орсон цоохор ирвэс, аргаль хонь, баданги хүдэр, халиун буга, нохой зээх, тагийн огдой, бараан хэрэм мэтийн олон зүйлийн хөхтөн, борцгор хотон, тоодог, зээрд шонхор, өгөөлэй шулганаа, усны цагаан сүүлт бүргэд зэрэг олон зүйлийн шувуудтай.

Хүснэгт 3. Кластер – II. Судалгаанд хамрагдах газар, нутаг

Кластер	ТХГН-ийн нэр	Аймаг	Сумын нэр	ТХГН-ийн талбай га	ТХГН-ийн эзлэх хувь
Кластер - II	Булган гол – Их онгогийн БЦГ	Ховд	Булган	286081	
	Мөнххайрхан уулын БЦГ	Баян-Өлгий	Булган	506094	
Хамгаалалтын захиргаа	Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа				



Зураг 4. Кластер- II: Судалгаанд хамрагдсан газар, нутаг

### 1.3. КЛАСТЕР-III: ХАН ХӨХИЙ НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР

**Хамгаалалтанд авсан үндэслэл:** Хан Хөхий нуруу нь их нууруудын хотгорыг зааглах ба цөл, хээрийн бүс нэмэгдэх үйл явцыг хязгаарладаг экологийн тэнцлийн хувьд чухал ач холбогдолтой газар юм. Олон улсын Гео-Биосферийн судалгааны бүсэд багтдаг. Хангайн нурууны хамгийн баруун талын салбар уулс болох Хан Хөхийн нуруу, нөгөө талаас Хяргас, Айраг нуур, Завхан, Хүнгүй голуудын адаг, тэдгээрийн эргэн тойрны цөлөрхөг ландшафт бүхий гандуу хуурай орчныг хамарсан ландшафтын эрс тэс хэв шинж тод ялгаран хосолсон, хангай нь говьтойгоо зэрэгцэн, цөлөрхөг, гандуу хуурай орчин нуур устай хоршин өвөрмөц орчин үүсгэсэн энэ нутгийг хамгаалах, зохистой ашиглах, аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор 221.598 га талбайтайгаар УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоолоор тусгай хамгаалалтанд авсан байна.




Зураг 5. Кластер III. Хан Хөхийн нурууны БЦГ

Хан Хөхийн нуруу нь Хангайн гол нурууны хамгийн баруун талын биеэ даасан томоохон салбар уулс бөгөөд хэд хэдэн нуруудаас бүрдэнэ. Энэ нуруу нь Их Нууруудын хотгор руу гүн түрж орсон тул Увс, Хяргас нуурын хотгорыг бие биеэс нь зааглан цөл хээрийн бүс нэмэгдэх үйл явцыг хязгаарлаж, экологийн тэнцвэрийг зохицуулдаг талаараа онцгой ач холбогдолтой. Хан Хөхийн нуруу нь 2001-2400 метрийн дундаж өндөр уулс зонхилох бөгөөд зах руугаа бүр ч намсан 1800 метр өндөртэй нам уулсад шилжинэ. Хамгийн өндөр цэг нь зүүн хэсэгт байх Дуулга уул (2928 м) байдаг. Хамгийн хойд цэг нь Новшт уул, өмнөд цэг нь Толийн уул, хамгийн баруун захын цэг нь Бунхант уул, зүүн захын цэг нь Хүнхийн уул юм. Хан Хөхийн нурууны БЦГ нь 221,598 га үүнээс ХАА зориулалтын газар 147,411 га, ой сангийн газар 62,632 га, усан сангийн газар 640 га, зам, шугам сүлжээний 2,616 га талбайг эзлэн оршдог. Ургамлан бүрхэвч нь мөн л бүслүүрлэг шинжтэй бөгөөд оройн

хэсгээр бушилзат, бушилз-улалжит бүлгэмдэл, тайгад хуш, хуш шинэсэн ой, ой, ойт хээрт шинэсэн ой тус тус зонхилно. Голуудын хөндий дагуу хус, бургас, улиас элбэгтэй. Эмийн ургамлаас юмдүүжин, алтан гагнуур, алтан хундага, таван салаа, эмийн бамбай, сөд, цээнэ элбэг ургана. Мөн самар, үхрийн нүд, тошлой, хад, аньс, гүзээлзэгэнэ, улаалзагана зэрэг жимс жимсгэнэтэй. Амьтдаас буга согоо, бор гөрөөс, гахай, шилүүс, чандага, туулай, үнэг, чоно, хярс, дорго, нохой зээх, мануул, тарвага, зурам элбэг тохиолдоно. Мөн тоншуул, хойлог, хур, сойр, ятуу, хөтүү, самрын шаазгай, ахуун, тас, бүргэд зэрэг жигүүртэн шувуудтай.

Хүснэгт 4. Кластер – III. судалгаанд хамрагдах газар, нутаг

Кластер	ТХГН-ын нэр	Аймаг	Сумын нэр	ТХГН-ын талбай га	ТХГН-ын эзлэх хувь
Кластер - III	Хан Хөхий нурууны БЦГ	Увс	Өндөрхангай	221598	14,6
			Зүүнхангай		67,1
			Цагаанхайрхан		17,4
Хамгаалалтын захиргаа	Хан Хөхийн нурууний УТХГН-ын хамгаалалтын захиргаа				




Зураг 6. Кластер- III: Судалгаанд хамрагдсан газар, нутаг

#### 1.4. КЛАСТЕР-IV: ЦАМБАГАРАВ УУЛЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР

**Хамгаалалтанд авсан үндэслэл:** Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Баяннуур сумдын заагт орших Цамбагарав уулын 113749 га талбайг УИХ-ын 2000 оны 29 дүгээр тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан. Энэ газрыг хамгаалалтад авснаар мөс судлалын ач холбогдолтой ба мөн ирвэсний хэвийн өсөлтийг хангах зорилготой. Цамбагарав нь мөнх цаст уул бөгөөд газрын доорх цэвэр усны асар их нөөцтэй. Цамбагаравын нурууг тойрон 200 шахам булаг шандтайгаас гадна эмчилгээний чанартай сайн рашаанууд бий. Ховор амьтан, ургамал ихтэйн дээр түүх соёлын дурсгалт зүйлс багагүй байдаг. Энэ бүгд нь аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломжийг бүрдүүлдэг учраас байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авчээ.

Цамбагарав уул нь Монгол Алтайн нурууны нэг салшгүй хэсэг бөгөөд ноён оргил Цаст уул нь далайн түвшнээс дээш 4298.4 м өргөгдсөн мөнх цаст уул юм.

Энд Монголын улаан номонд орсон устаж болзошгүй болон хөнөөгдөж байгаа алтан гагнуур, дөрвөлсөн мүгээ, зэрлэг сонгино,




Зураг 7. Кластер IV. Цамбагарав уулын БЦГ

вансэмбэрүү, балчингарав зэрэг ургамлаас гадна таван салаа, лантанз, агь, хөмүүл, мангир зэрэг эмийн ургамал ургадаг. Амьтдаас ховордсон аргаль, янгир, ирвэс болон тарвага, зурам, чоно, үнэг, суусар, цагаан үен, хярс зэрэг амьтад нилээд өргөн тархдаг. Шувуудаас хойлог, ятуу, харцага, тас, бүргэд ихтэй. Цамбагаравын нуруунд түүх, соёлын дурсгалт зүйлс багагүй бий. Эрдэнэбүрэн сумын нутаг нь ойрадын хаан Галдан Бошигтын уугуул нутаг билээ. Мөн Ямаатын эх орчмоор хадны сүг зураг, хиргисүүр нилээд бий. Цамбагаравын нурууг тусгай хамгаалалтад авснаар Монгол Алтайн мужийн мөнх цас, мөсний ландшафтыг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх боломж бүрджээ.

Хүснэгт 5. Кластер – IV. судалгаанд хамрагдах газар, нутаг

Кластер	ТХГН-ын нэр	Аймаг	Сумын нэр	ТХГН-ын талбай га	ТХГН-ын эзлэх хувь
Кластер - IV	Цамбагарав уулын БЦГ	Ховд	Мянгад	113749	1
			Эрдэнэбүрэн		51,8
Хамгаалалтын захиргаа	Хар ус нурууны УТХГН-ийн хамгаалалтын захиргаа				



Зураг 8. Кластер- IV: Судалгаанд хамрагдсан газар, нутаг

## 2. КЛАСТЕР НУТГИЙН ОЙН САНГИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ

Судалгаанд хамрагдсан кластер нутгийн ойн сангийн суурь үзүүлэлтийг тогтоохдоо аймаг, сумын түвшний ой зохион байгуулалтын хээрийн хэмжилт тооллого хийсэн дээж талбайн мэдээ болон сумын хэмжээнд нэгтгэн хамгийн сүүлд /Хүснэгт 6/ боловсруулсан мэдээ, материалыг суурь мэдээлэл болгон ашиглав.

Ой зохион байгуулалт нь ойн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүн, ойн чанар, төлөв байдал, ойн өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагаа<sup>1</sup> юм. Сумын түвшний ой зохион байгуулалтын ойн таксацын мэдээ болон ойн тархалтын зургийн мэдээнээс кластер нутагт хамаарах тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн дагуу дотоод бүсчлэл тус бүрээр мэдээг салган кодлож ойн мэдээг зургийн мэдээтэй нэг бүрчлэн тулгаж талбайг гаргаж тооцоог нэгтгэн боловсруулсан болно.

Хүснэгт 6. Судалгаанд ашигласан ой зохион байгуулалтын мэдээ

Кластерийн нэр	Аймгийн нэр	Сумын нэр	ТХГН-ийн нэр	Ой зохион байгуулалтын он
Кластер-I	Увс	Түргэн	Түргэн уулын ДЦГ	2020
Кластер-II	Ховд	Булган	Булган гол-Их Онгогийн БЦГ	2020
	Баян-Өлгий	Булган	Мөнххайрхан уулын БЦГ	2017
Кластер-III	Увс	Өндөрхангай	Хан Хөхийн нурууны БЦГ	2020
		Зүүнхангай		
		Цагаанхайрхан		
Кластер-IV	Ховд	Мянгад	Цамбагарав уулын БЦГ	2020
		Эрдэнэбүрэн		

Ойн сангийн суурь үзүүлэлтэд (i).ойн талбай, (ii). нөөц, (iii). ойн бүсийн төрөл, (iv). ойг бүрдүүлэгч модны төрөл, хэв шинж, ургах орчны нөхцөл болон (v). насны анги, насны бүлэг, (vi). ойн өтгөрөл, (vii). чансаа, (viii). өсөлт зэрэг ойн таксацын үндсэн үзүүлэлтүүдийг ТХГН-ын ойн тогтвортой менежментийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийн 1-р хавсралтыг удирдамж болгож, Кластер нутгийн Тусгай хамгаалалттай газар тус бүрээр тооцоолон гаргаж хүснэгт, графикаар үзүүлэв

Ойн сангийн суурь үзүүлэлтийн тодорхойлолтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

<sup>1</sup> Ойн тухай хуулийн 3.1.13



**Ойн сан бүхий газар:** Ойн сан гэж Монгол улсын нутаг дэвсгэрт ургадаг бүх төрлийн мод, бут, заг, сөөг, таримал ойн нөөцийг хамруулан ойлгоно.<sup>2</sup> Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сан бүхий газарт хамаарна.<sup>3</sup> Ойн сангийн талбайг ойн ба ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваана. Ойн талбай нь байгалийн ой, сөөг торлог, таримал ойгоос бүрдсэн ойгоор бүрхэгдсэн талбай болон тармаг ой, шатсан ой, мод бэлтгэсэн газар, ойжих талбай зэрэг газрыг хамруулсан ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагдана. Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, жижиг нуур цөөрөм, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд орно.

**Ойн бүс:** Ойн сан бүхий газрыг хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи-эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан Ойн тухай хуульд заасны дагуу хамгаалалтын ба ашиглалтын бүсэд хуваадаг. “Ойн тухай” хуулийн дагуу Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Ашиглалтын бүсийн ойгоос иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага мод, ойн дагалт нөөцийг ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан менежментийн төлөвлөгөөний дагуу ашиглаж болохыг хуульчилж өгсөн. ТХГН-ийн хамгаалалтын дэглэм, түүнд авч хэрэгжүүлэх ойн арга хэмжээ нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, өсвөр модыг арчлан тордож өсөлт сайтай эрүүл ойг ургуулах, хатсан, унасан модыг цэвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Газар нутгийг хамгаалалтад авч ойн экосистемийг хамгаалснаар тармаг ой, түймэрт өртсөн болон мод бэлтгэсэн зэрэг ойгоор бүрхэгдээгүй ойн талбайг нөхөн сэргээж, өсвар модыг хамгаалж арчлан ургуулж байгалийн сэргэн ургалтыг дэмжиж байгалийн ой, таримал ой, бут сөөгний талбайг нэмэгдүүлэх замаар ойгоор бүрхэгдсэн ойн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх явцад ойд хяналт мониторинги хийж ойн сангийн талбайн шилжилтийг

---

<sup>2</sup> Ойн тухай хуулийн 3.1.2

<sup>3</sup> Ойн тухай хуулийн 5.2

хянах боломжтой бөгөөд ойн сангийн ойгоор бүрхэгдээгүй талбайгаас ойгоор бүрхэгдсэн талбайд шилжиж газар нутгийн ойрхог чанарыг нэмэгдүүлэх нь ойн экосистемийг хамгаалах чухал шалгуур үзүүлэлт болно.

**Ойн нөөц:** Нэг га талбайд ургасан ургаа модны ишний нийт эзэлхүүнийг ойн нөөц гэнэ. Ойн сангийн ургаа ойн нийт нөөц нь байгалийн ойн болон тармаг ой, бүлэг модны нөөцөөс бүрдэх ба ойд байгаа хатсан, унасан модны нөөцийг тооцож бүртгэнэ. Ой зохион байгуулалтын үед ойн ялгарал тус бүрт газрын чиглэл, налууг тодорхойлж ургаа ойн нөөцийг налуугийн бүлгээр ангилна. Налуугийн бүлэг нь ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд чухал үзүүлэлт бөгөөд ойн ашиглалт, нөхөн сэргээлт, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх технологи болон техник, тоног төхөөрөмжийг сонгоход ашиглагдана.

**Ойн таксацын дундаж үзүүлэлт:** Ойн хэмжилт тооллогоор ойн талбай, нөөц, модны өсөлт, дундаж нас, өтгөрөл, ойн ургах орчны үнэлгээ болох бонитет, модны дундаж өндөр, диаметр зэрэг таксацын дундаж үзүүлэлтүүдийг тогтоодог.

**Ойн насны анги ба насны бүлэг:** Ой зохион байгуулалтын судалгаагаар модны жилийн цагирагийн дээж авч модны төрөл тус бүрээр ялгарал бүрд ойн үелэлийг үүсгэсэн дундаж насыг тодорхойлдог. Модлогийн таваарлаг чанар болон өсөлтийн явцтай уялдуулан модны насны ангийг тодорхойлох ба шилмүүст модонд насны нэг ангийг 20 жил, навчит модонд 10 жил байна. Ойг насны хувьд жигд тархалттай, зөв бүтэцтэй ургуулахын тулд ойд арчилгаа цэвэрлэгээг тогтмол хийх, байгалийн аясаар нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, зориудаар тарьж ургуулах ажлыг тодорхой цаг хугацаанд нь технологийн дагуу явуулна. Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж явуулахдаа харгалзан үзэх чухал үзүүлэлт нь ойн насны бүлэг бөгөөд ойг залуу, дунд насны болц гүйцэж буй, болц гүйцсэн хөгшин ой гэж ангилж бүлэглэдэг. Залуу болон дунд насны ойд арчилгаа, цэвэрлэгээг явуулж моддын ургах нөхцөлийг бүрдүүлэн тэжээлийн талбайг нэмэгдүүлж модны өсөлт хөгжилтийг дэмждэг. Ойн насны бүлгийн тооцоо нь тухайн бүс нутгийн ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх үндэслэл болно.

**Ойн чансаа буюу бонитет:** Ой моддын ургах орчныг харуулсан үнэлгээг ойн чансаа буюу бонитет гэх модны өндөр, диаметр, өсөлт, ургалтаас хамааруулан үнэлнэ. Модны төрөл, насны хувьд ижил боловч хөрс, орчны нөхцөл, уур амьсгалын байдлаас шалтгаалан ойн өсөлт хөгжилт харилцан адилгүй байдаг. Ойн ургах орчны нөхцөл хэдий чинээ сайн байвал модны өсөлт, өндөр, диаметр зэрэг

үзүүлэлт сайн байна гэсэн зарчимд тулгуурласан үнэлгээ юм. Бонитетийн 1-р ангид өсөл хөгжилт сайтай ойг хамруулдаг бол 5-р ангид өсөлт муутай, таваарлаг чанар багатай ойг оруулан тооцдог.


**Ойн өтгөрөл:** Ойн орон зайн ашиглалтын түвшнийг өтгөрөл гэсэн үзүүлэлтээр илэрхийлдэг ба ойн нөөцийг тогтооход ашигладаг голлох үзүүлэлт юм. Ургаж байгаа орчныхоо байгалийн боломж, орон зайг бүрэн ашигласан ойг хэвийн ой гэж үзэж 1,0 гэсэн баллаар үнэлдэг. Хэвийн ой нь орчны орон зайгаа бүрэн ашиглан ургасан учир ижил төрлийн адил насны ойгоос модны нөөц нь их байна. Ойн өтгөрлийг 0,3-1,0 гэж үнэлдэг бол тармаг ойн өтгөрөл 0,1-0,2 байна.

Ойн өтгөрөл 0,5-аас дээш ойд сийрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх замаар модны тэжээлийн талбайг нэмэгдүүлж модны өсөлтийг сайжруулна. Харин гадны нөлөөнд өртсөн, мод бэлтгэж хэт сийрэгжүүлсэн өтгөрөл багатай ойд байгалийн сэргэн ургалтыг дэмжих, өсвөр модыг хамгаалах арга хэмжээг явуулахаас гадна хэт сийрэгжиж хээрших хандлагатай бол зориудын аргаар ойжуулах шаардлагатай болдог.

## 2.1. КЛАСТЕР-I ТҮРГЭН УУЛЫН ДЦГ-ЫН ОЙН САНГИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ


Увс нуурын ай савын кластерийн ДЦГ-т хамаарах “ТҮРГЭН УУЛЫН ДЦГ”-нь засаг захиргааны хувьд Түргэн, Тариалан, Бөхмөрөн, Ховд сумдын нутагт оршино. Судалгаанд Түргэн сумын нутгаас ДЦГ-т хамрагдаж байгаа хэсгийг сонгон авч 2020 оны сумын түвшний ой зохион байгуулалтын материалыг ашиглан ойн суурь үзүүлэлтийг тогтоов.

Увс аймгийн Түргэн сумын 17296 га ойн сан бүхий талбайгаас 83,5% буюу 14448 га талбай “ТҮРГЭН УУЛЫН ДЦГ”-т хамрагдаж байгаа бөгөөд ойн сан бүхий газар нь 50 хэсэглэл, 1032 ялгаралд хуваагдаж байна.



Зураг 9. Ойн сан бүхий газрын талбайн төрөл

Түргэн уулын ДЦГ-т хамрагдаж буй ойн сан бүхий газрын 98,7%-нь ойн талбай, 1,2%-нь ойн бус талбайгаас бүрдэнэ.



Зураг 10. Ойн сангийн талбайн газрын төрлийн эзлэх хувь

Ойн сангийн талбайн 94%-нь байгалийн ой, 4%- нь тармаг ой ба мод бэлтгэсэн талбай байна.

Хүснэгт 7. Ойн сангийн талбайн дүнгийн хүснэгт /газрын төрлийн ангилалаар/ /талбай-га/

Бүсийн төрөл	ОЙН ТАЛБАЙ							ОЙН БУС ТАЛБАЙ Цагаан энгэр	Ойн сангийн талбай
	Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй			Ойн талбайн дүн		
	Байгалийн ой	Сөөг	Дүн	Тармаг ой	Мод бэлтгэсэн талбай	Дүн			
Онгон бүс	121		121	11		11	132		132
Хамгаалалтын бүс	930		930	47		47	977	41	1018
Хязгаарлалтын бүс	4379		4379	156		156	4535	66	4601
Орчны бүс	8257		8257	251	111	362	8619	78	8697
<b>ДЦГ-ын дүн</b>	<b>13687</b>	<b>0</b>	<b>13687</b>	<b>465</b>	<b>111</b>	<b>576</b>	<b>14263</b>	<b>185</b>	<b>14448</b>

### ➤ ОЙН БУС

“ТҮРГЭН УУЛЫН ДЦГ”-т Түргэн сумаас хамрагдаж байгаа ойн сан бүхий газар нь Ойн тухай хуулийн дагуу Хамгаалалтын бүсэд хамрах ба Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн дагуу дотоод бүсчлэлд хуваагдана. Түргэн сумын ой зохион байгуулалтын материалд тус газар нутгийн ойг ДЦГ, Ногоон бүс, Хориотой зурвас, Ашиглалтын бүс, Орон нутгийн хамгаалалттай газар гэж олон бүсэд ангилж тооцоог гаргасан байгаа тул Түргэн уулын ДЦГ-т хамаарах ойн талбайг шууд авч ашиглах

боломжгүй байв. Иймээс ойн бүсийн ангилалыг Түргэн уулын ДЦГ-ын дотоод бүсчлэлийн хилийн цэсийн дагуу салгаж ангилан тооцоог нарийвчлан гаргасан.

Судалгаанд хамрагдаж байгаа “ТҮРГЭН УУЛЫН ДЦГ”-ын ойн сан нь “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн дагуу Онгон бүс, Хамгаалалтын бүс, Хязгаарлалтын бүс, Орчны бүсэд хуваагдана.

*Хүснэгт 8. Ойн сангийн талбай, бүсийн төрлөөр*

Д.д	ДЦГ-ын дотоод бүсчлэл	Ойн сангийн талбай, га	Эзлэх хувь
1	Онгон бүс	132	1
2	Хамгаалалтын бүс	1018	7
3	Хязгаарлалтын бүс	4601	31,8
4	Орчны бүс	8697	60,2
<b>Нийт дүн</b>		<b>14448</b>	<b>100</b>


➤ **ОЙН НӨӨЦ**

“ТҮРГЭН УУЛЫН ДЦГ”-ын ойн сан дахь ургаа ойн нийт нөөц 1521,8 мянган шоометр байна. Ургаа ойн нийт нөөцөөс 98% буюу 1485,8 мянган шоометр нь байгалийн ойн нөөц, 1,2%-нь тармаг ойн нөөц, 1 орчим хувь нь бүлэг модны нөөц байна. Ойн санд түймэр, хөнөөлт шавж болон бусад гадны нөлөөнд өртөж ургах чадвараа алдсан 660 шоометр хатсан мод, 136 шоометр унасан модны нөөц байна.

*Хүснэгт 9. Ойн нөөцийн дүнгийн хүснэгт*

Бүсийн төрөл	Ургаа ойн нөөц	Тармаг ойн нөөц	Бүлэг модны нөөц	Нийт ургаа ойн нөөц	Хатсан модны нөөц	Унанги модны нөөц	Ойн нөөцийн налуугийн бүлгийн тархалт			
							Налуугийн бүлэг 1	Налуугийн бүлэг 2	Налуугийн бүлэг 3	Налуугийн бүлэг 4
							(0-15хэм)	(16-25хэм)	(26-35хэм)	(36хэмээс дээш)
Онгон бүс	10020	220		10240					10020	
Хамгаалалтын бүс	97782	1980		99762	40	8		22	97760	
Хязгаарлалтын бүс	473473	5200	7710	486383	580	116		40569	420514	12390
Орчны бүс	903460	10420	10470	924350	40	12	9620	94690	711050	88100
<b>Нийт дүн</b>	<b>1484735</b>	<b>17820</b>	<b>18180</b>	<b>1520735</b>	<b>660</b>	<b>136</b>	<b>9620</b>	<b>135281</b>	<b>1239344</b>	<b>100490</b>

Налуугийн бүлгийн ангилалаар ойн нөөцийн 0,6%-нь 0-15 хэмийн налуугийн 1-р бүлэг, 9%-нь 16-25 хэмийн налуугийн 2-р бүлэг, 83,4%-нь 26-35 хэмийн налуутай 3-р бүлэг, 7%-нь 36 хэмээс дээш налуутай 4-р бүлэгт тус тус хамрагдаж байна. Ойн нөөцийн 90 гаруй хувь нь 26 хэмээс дээш налуутай өндөр уулын бүсэд тархан ургасан байна.



Зураг 11. Ойн нөөцийн налуугийн бүлгийн ангилал

### ➤ ОЙГ БҮРДҮҮЛЭГЧ МОДНЫ ТӨРӨЛ

Судалгаанд хамрагдсан газар нутгийн ой нь гарал үүслийн хувьд өөрөө аясаараа ургасан байгалийн ой бөгөөд дан бүрэлдэхүүнтэй шинэсэн ой зонхилон тархах ба голын хөндийгөөр улиас, бургас, сөөг тархан ургана.

Хүснэгт 10. Ойг бүрдүүлэгч модны төрөл

Бүсийн төрөл	Модны төрөл	ОЙН ТАЛБАЙ						Ойн талбайн
		Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй			
		Байгалийн ой	Сөөг	Дүн	Тармаг ой	Мод бэлтгэсэн талбай	Дүн	
Онгон бүс	шинэс	121		121	11		11	132
Хамгаалалтын бүс	шинэс	930		930	47		47	977
Хязгаарлалтын бүс	шинэс	4379		4379	156		156	4535
Орчны бүс	шинэс	8225		8225	231	111	342	8567
	улиас	27		27	20		20	47
	бургас	5		5			0	5
	Дүн	8257	0	8257	251	111	362	8619
<b>ДЦГ-ын дүн</b>		<b>13687</b>	<b>0</b>	<b>13687</b>	<b>465</b>	<b>111</b>	<b>576</b>	<b>14263</b>

Тус газар нутгийн ойд уулын цэвдэгт, дунд шавранцар, чийглэг хөрс бүхий сорвоо алаг өвст шинэсэн ой, хүлэрлэг ялзмагт, цэвдэгт хайргархаг нимгэн хөрс бүхий алаг өвст ритид хөвдөт шинэсэн ойн хэв шинж зонхилон тархана.

## ➤ ОЙН ТАКСАЦЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ

Таксацын дундаж үзүүлэлтийн тооцоогоор ойн дундаж өтгөрөл 0.52, 1га ойн нөөц 108.5м<sup>3</sup>, ойн 1га-ийн дундаж өсөлт 0,93м<sup>3</sup>, шинэсэн ойн дундаж нас 116 жил, улиасны дундаж нас 83 жил байна. Шинэсэн ойн нөөцийн 55%-нь болц гүйцсэн хөгшин ой тархан ургаж байна.


### Хүснэгт 11. Таксацын дундаж үзүүлэлтүүд

Модны төрөл	Байгалийн ойн талбай /га/	Бүх нөөц /шоометр/	Болц гүйцсэн ойн талбай /га/	Болц гүйцсэн ойн нөөц /шоометр/	Бүх дундаж өсөлт /шоометр/	Ойн дундаж үзүүлэлт			Болц гүйцсэн ойн 1га-н нөөц /шоометр/	Байгалийн ойн 1га-н нөөц /шоометр/	1га ойн өсөлт /шоометр/
						Нас /жил/	Бонитет	Өтгөрөл			
Дархан цаазат газрын Онгон бүс											
Шинэс	121	10020	0	0	106	94	5	0.44	0	82.8	0.87
Дархан цаазат газрын Хамгаалалтын бүс											
Шинэс	930	97782	370	47862	862	113	5	0.54	129	105.1	0.92
Дархан цаазат газрын Хязгаарлалтын бүс											
Шинэс	4379	473473	2439	281504	4002	118.3	5	0.53	115.4	108.2	0.91
Дархан цаазат газрын Орчны бүс											
Шинэс	8225	902080	4122	489420	7741	116.5	4.86	0.52	118.7	109.7	0.94
Улиас	27	1310	27	1310	15	83.5	4.96	0.31	48.5	48.5	0.58
Бургас	5	70			2	25	5	0.34		14	0.56
<b>Нийт дүн</b>	<b>13687</b>	<b>1484735</b>	<b>6958</b>	<b>820096</b>	<b>12731</b>	<b>0</b>	<b>4.89</b>	<b>0.52</b>	<b>117.8</b>	<b>108.5</b>	<b>0.93</b>

## ➤ ОЙН НАСНЫ АНГИ БА НАСНЫ БҮЛЭГ

205	6	91.32175 47.000017	9	6	10Ш/50/, Д-11, Н-11, Бонитет-4 Өтгөрөл-0.9, Нөөц-150м <sup>3</sup> /га хэв шинж ногоон хөвд, улалжит шинэсэн ой, сэргэн ургалт дунд 1000ш/га, налуу БХ-18°, сөөгнөөс харгана, үхрийн нүд дунд зэрэг ургасан.			Арчилгааны огтлолтын сийрэгжүүлэх хэлбэрийг хийнэ.	Модны ургалтын эрчим сайжирна. Дундаж диаметр 2см, өндөр 100см нэмэгдэнэ.
Кластер – 3. Увс аймаг Хан Хөхийн нурууны БЦГ									
1518	565	94.35698 49.38608	17	5	7Ш/70/, Д-22, Н-13, 2Ш/120/, д-34 н-17, М-150м <sup>3</sup> /га Р-0.7	Хан Хөхийн нурууны өтгөрөл сайтай дунд насны шинэс, залуу хушин ойг төлөөлүүлж сонгосон.	2020	Арчилгааны огтлолтын завсрын хэлбэрийг хийнэ.	Үүний үрд модлогийн чанар дээшилж, дундаж диаметр 2- 2.5см, дундаж өндөр 60-90 см өснө
1511	254 1	94.59375 49.455761	29	19	8Ш/160/, Д-30, Н-19, 2Ш/60/, д-12 н-8, М-160м <sup>3</sup> /га Р-0.7		2014	Арчилгааны огтлолтын завсрын хэлбэрийг дагалдах модонд хийнэ.	
1511	245	94.95679 49.39545	43	18	7Хш/60/, Д-20, Н-11, 3Ш/160/, д- 32 н-17, М-180м <sup>3</sup> /га Р-0.8		2020	Арчилгааны огтлолтын сийрэгжүүлэх хэлбэрийг	Хушин ойн тэжээлийн талбай нэмэгдэж ургалтын

								залуу хушинд хийнэ. Дээрээс сийрүүлэх зорилгоор хөгшин модыг авч болно	эрчим сайжрах нөхцөл бүрдэнэ. Модны таваарлаг чанар дээшилнэ.
Кластер – 4. Ховд аймаг Цамбагарав уулын БЦГ									
1615	8	91.361333 48.63050	Судалгааны хилээс гадна, Ховд голын шугуй	10Ул/80/, Д-41, Н-13, Бонитет-5 өтгөрөл-0.7, нөөц-110м³/га, хэв шинж үетэн алаг өвст, татмын улиасан ой, налуу БХ-1°, сөөг бургас сийрэг ургасан	Ховд голын дагуух Улиас болон бургасан шугуйг төлөөлнө	Шинээр авсан цэг 2021	-	-	
1610	16	91.432361 48.626194	Судалгааны хилээс гадна, Ховд голын шугуй	10Ул/80/, Д-46, Н-16, Бонитет-5 өтгөрөл-0.3, нөөц-60м³/га, хэв шинж үетэн алаг өвст, татмын улиасан ой, налуу БХ-1°, сөөг бургас хангалттай ургасан			Цагаан бургасын бутыг сийрүүлэх, хатсан унасан цэвэрлэх	Цагаан бургас залуужина	
1615	7	91.337194 48.668083	Сэжигтийн хавцал	Ойгүй газар		Шинээр авсан цэг 2021	Орон нутгийн экологийн байдлыг хамгаалах, нутгийн иргэдийг дэмжих		

Дугаарын тайлал: 205 – Баян-Өлгий аймаг Булган сум, 1511 – Увс аймаг Өндөрхангай сум, 1514 – Увс аймаг Түргэн сум, 1518 – Увс аймаг Цагаанхайрхан сум, 1610 – Ховд аймаг Мянгад сум, 1615 – Ховд аймаг Эрдэнэбүрэн сум


### 3.4. ОЙН ЭКОЛОГИ – ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 35. Ойн экологи-Эдийн засгийн үнэлгээ


Кластер - I. Увс аймаг Түргэн сум, ТҮРГЭН УУЛЫН ДЦГ				Төлбөрийн муж: 1				
Үнэлгээний төрөл	Үнэлгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг		Нийт үнэлгээ, төг		Үнэлгээний нийт дүн
				шууд үр ашгийн үнэлгээ	шууд бус үр ашгийн үнэлгээ	шууд үр ашгийн үнэлгээ	шууд бус үр ашгийн үнэлгээ	
Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ	Шинэс	шоометр	1483355	249,877	320,339	370,656,297,335	475,176,457,345	845,832,754,680
	Улиас	шоометр	1310	124352	159,418	162,901,120	208,837,580	371,738,700
	Бургас	шоометр	70	110274	141,370	7,719,180	9,895,900	17,615,080
<b>Дүн</b>			<b>1484735</b>	<b>484503</b>	<b>621127</b>	<b>719,358,561,705</b>	<b>922,208,996,345</b>	<b>1,641,567,558,050</b>
Ойгоор бүрхэгдсэн талбайн экологи-эдийн засгийн үнэлгээ	Шинэс	га	13655	33,983,181	43,566,383	464,040,336,555	594,898,959,865	1,058,939,296,420
	Улиас	га	27	11,168,182	14,317,591	301,540,914	386,574,957	688,115,871
	Бургас	га	5	7,179,545	9,204,165	35,897,725	46,020,825	81,918,550
<b>Дүн</b>			<b>13687</b>	<b>52330908</b>	<b>67088139</b>	<b>464,377,775,194</b>	<b>595,331,555,647</b>	<b>1,059,709,330,841</b>
Ойгоор бүрхэгдээгүй талбайн экологи-эдийн засгийн үнэлгээ	Тармаг ой	га	465	13,593,272	17,426,553	6,320,871,480	8,103,347,145	14,424,218,625
	Мод бэлтгэсэн талбай	га	111	9,062,182	11,617,702	1,005,902,202	1,289,564,922	2,295,467,124
<b>Дүн</b>			<b>576</b>	<b>22,655,454</b>	<b>29,044,255</b>	<b>7,326,773,682</b>	<b>9,392,912,067</b>	<b>16,719,685,749</b>
<b>Шууд үр ашгийн үнэлгээ:</b> Ойн нөөц, ойн дагалт баялгийн үнэлгээ								
<b>Шууд бус үр ашгийн үнэлгээ:</b> Ойн ус зохицуулах, хөрс хамгаалах, нүүрсхүчлийн хийгшингээх, нийгэм, амралт зугаалгын ач холбогдол зэрэг экологийн ач холбогдлын үнэлгээ								

## 4. КЛАСТЕР НУТАГ ТУС БҮРИЙН ОЙН БҮРХЭВЧИЙН ЗУРАГ БОЛОН НЭН ХОВОР, ХОВОР, УНАГАН УРГАМЛЫН ТАРХАЛТЫН ЗУРАГЛАЛ


### 4.1. Кластер-I: Түргэн уулын ДЦГ-ын ойн бүрхэвчийн зураг



Зураг 26. Түргэн уулын ДЦГ: Ойн тархалт




Зураг 27. Түргэн уулын ДЦГ: Ойн төлөв байдал




Зураг 28. Түргэн уулын ДЦГ: Ойн арга хэмжээний төлөвлөлт

## 4.2. Кластер-II Булган гол, Их Онгогийн БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ-ын ойн бүрхэвчийн зураг




Зураг 29. Ойн тархалтын зураг (Булган гол-Их Онгогийн БЦГ)






Зураг 30. Ойн тархалтын зураг (Мөнххайрхан уулын БЦГ)




Зураг 31. Ховор ургамлын байршил болон суурьшлын бүс (Булган гол-Их Онгогийн БЦГ)




Зураг 32. Ойн төлөв байдлын зураг (Мөнххайрхан уулын БЦГ)


### 4.3. Кластер-III Хан Хөхий нурууны БЦГ-ын ойн бүрхэвчийн зураг



Зураг 33. Ойн тархалтын зураг (Хан Хөхий нурууны БЦГ)




Зураг 34. Ойн төлөв байдлын зураг (Хан Хөхий нурууны БЦГ)



Зураг 35. Ойн арга хэмжээний төлөвлөлтийн зураг (Хан Хөхий нурууны БЦГ)

#### 4.4. Кластер-IV Цамбагарав уулын БЦГ-ын ойн бүрхэвчийн зураг



Зураг 36. Нэн ховор, ховор, унаган ургамлын тархалтын зураглал

Мөнх цаст Цамбагарав хайрханы ам, жалга, судаг бүрээс сэрүүн цэнгэг горхи булаг хоржигнон урсаж, олон нуур цөөрмийг үүсгэн, баян бүрд, төгөл ой ургах нөхцөл болно. Үүнийгээ дагаад ховор сонин ургамал урган, ан амьтан байрших таатай нөхцөл бүрдсэн. Гэтэл ой ургамал нь судалгаа хийгдээгүй. Бид аман зураглалаар 18 га шинэсэн ойг зурагт тэмдэглэж, 246 га баян бүрд хөрсний гулгалтанд сүйдсэнг зураглав.

## 5. КЛАСТЕР НУТГИЙН ТХГН-ИЙН ОРЧНИЙ БҮСИЙН СУМУУДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 5.1. УВС АЙМГИЙН ТҮРГЭН УУЛЫН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Түргэн сум:** Увс аймгийн баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос 1370 км, Аймгийн төвөөс 32 км зайд байрладаг. Увс аймгийн Улаангом, Сагил, Давст, Бөхмөрөн, Ховд, Тариалан сумуудтай хиллэдэг. Түргэний уулсын ноён оргил Дэглий цагаанаас зүүн зүг Увс нуурын хөвөөний нам дор газар, өмнө талын Хөх нуураас хойд зүгт ачит нуур хүртэлх уулархаг болон хээр талын бүсийн 225 мянган га нутаг дэвсгэрийг эзлэн оршино. Сумын нийт нутгийн 1/3-ийг уулс эзэлдэг, мөнх цаст оргил, ян сарьдаг, өндөр уулын нуга, өндөр уулын хээр, уулын ой, уулын хээрийн бүсүүдтэй бөгөөд Түргэний уулс Монгол алтайн уулын системд багтах боловч харьцангуй хойд өргөрөгт байрлах учраас хур тунадас, чийг хангамж илүүтэй, ой болон нугархаг газар их талбайг эзэлдэг онцлогтой. Засаг захиргааны 3 багтай (Баянхайрхан, Аршаан, Эрдэнэхайрхан). Нийт газар нутгийн хэмжээ 225342 га. Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ын Хандгайтын чиглэлийн олон улсын чанартай авто зам дайран өнгөрдөг. Уг замаас сумын төв хүртэл 3 км сайжруулсан шороон замтай. Түргэний голд 128 м бетон гүүр тавигдсан. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Хүснэгт 36. Түргэн Сумын хүн ам болон малын тоо


Аймгийн нэр	Сумын нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо	Малын тоо \төрлөөр\				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Увс	Түргэн	592	2079	358	4678	7889	78315	

### 5.2 ОЙН НӨӨЦ, ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

Кластер–I бүс нутгийн Түргэн уулын ДЦГ-т хамрагдах ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын талаар дүн шинжилгээ хийхийн тулд Увс аймгийн Түргэн сумын ойн төлөв байдал, ойн менежментэд тулгарч буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, ойн менежментийн оролцогч талуудын саналыг оролцооны аргаар тодорхойлов.




Зураг 37. Түргэн сумын оролцогч талуудтай хийсэн уулзалт



Хүснэгт 37. Кластер-I: ойн аж ахуйн арга хэмжээ

№	Аж ахуйн арга хэмжээ, га/м <sup>3</sup>	Кластер I
1	Арчилгааны огтлолт	930
		21462
2	Цэвэрлэгээний огтлолт	33
		990
3	Ойжуулалт	195
4	БСУ туслах	-
5	Самар түүх	-
6	Жимс түүх	-
7	Өндөр хожуулыг тайрах	2750
		2700
<b>Кластер - I</b>		<b>3908</b>
		<b>25152</b>



Зураг 38. Оролцооны аргаар зурагласан зураг

Дээрх хүснэгтэнд төлөвлөгдсөн ойн аж ахуйн арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлснээр ойн орчин, байгалийн ургалт сайжирч, модлогийн чанар дээшилнэ. Арчилгаа цэвэрлэгээний огтлолтоос гарах модыг авч ашиглах боломжтой. Судалгаанд хамрагдсан нийт нутгийн хэмжээгээр 3908 га ойгоос 25152 м<sup>3</sup> нөөц бүхий модлог авч ашиглах боломжтой байна.

Хүснэгт 38. Кластер-I: Ойгоос олж байгаа орлого

Увс аймгийн Түргэн сум	
Сумын ойн анги	Сум дундын ойн ангитай ( Түргэн, Сагил, Давст, Бөхмөрөн, Ховд, Улаангом, Тариалан)



	5 га мод үржүүлгийн газартай үүнээс 2 га хашаалсан, 2 хүлэмжтэй 3 хүн ажилладаг	
<b>ОМБ</b>	1	3 хүн ажилладаг
<b>Нөхөрлөл</b>	ойн нөхөрлөл - 2, байгаль хамгаалах чиглэлээр -3	1 нөхөрлөлд 12-15 өрх 500 хүн
	Эзэмшлийн талбай, га - 200 га хариуцуулдаг	
<b>Сумын татварын нийт орлого /төг/: 74,595,400 (2020 он)</b>		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	-	
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	-	
Ойн нөөц ашигласны төлбөр	1,735,180.00	
<b>Модны хэрэгцээ</b>		
Түлшний модны хэрэгцээ	500-900 м <sup>3</sup>	592 өрх (2-3 м <sup>3</sup> )
Хэрэглээний мод	200-300 м <sup>3</sup>	
Мужааны жижиг цех - байхгүй		

### 5.3 SWOT ДҮН ШИНЖИЛГЭЭ

Кластер–I бүс нутгийн Түргэн уулын ДЦГ-ын орчны бүс нутагт хамрагдах Түргэн сумын ойн нөөц болон дагалт баялаг ашиглалтын төлөв байдлад SWOT шинжилгээг орон нутгийн оролцогч талуудаас гаргасан саналыг тусгасан хувилбараар үзүүлэв.

Хүснэгт 39. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Авч ашиглах модны нөөцтэй</li> <li>• Дэд бүтэц хөгжсөн</li> <li>• Аймагтай ойрхон зах зээлтэй</li> <li>• МҮГ –тай</li> <li>• Хадлангийн талбайн менежмент сайтай</li> <li>• Ойн сангийн ан амьтанд өгөх өвс, тэжээл нөөцөлдөг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ой доройтолд орсон</li> <li>• ОМБ байхгүй</li> <li>• Жимс, самарын нөөц багатай</li> <li>• МҮГ-ын үйл ажиллагаа сул</li> <li>• Ойн аж ахуйн мэргэжилтэн хангалтгүй</li> <li>• Орчин үеийн тоног төхөөрөмж байхгүй</li> <li>• Зүсвэрийн хөрөө рамаас гарч байгаа үртсийг ашигладаггүй</li> <li>• Мэргэжил аргагүйн шаталсан сургалт хангалтгүй</li> </ul>
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Арчилгаа цэвэрлэгээний огтлолтоос гарах модыг авч ашиглах боломжтой</li> <li>• МҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах</li> <li>• Бүс нутгийн онцлогт тохирсон шилмүүс модны үрийн нөөц бүрдүүлж, ойжуулалтын ажлыг өргөн хүрээнд хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Арчилгааны огтлолт хийх нэрийдлээр модыг зүй бусаар огтлох</li> <li>• Хэрэгцээг харж сорчилж огтлох</li> <li>• Өтгөрлийг хэт багасгаснаар ойг доройтолдууруулах</li> <li>• Тендерээр ойн мэргэжилтэнгүй байгууллага эрхийг авах магадлалтай</li> <li>• Модны хулгай ихсэх эрсдэлтэй</li> </ul>

#### ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛ:

- Мод үржүүлгийн 5 га газар байгаа боловч 2 га газрыг хашаалсан багаа үлдсэн 3 га газрыг хашаалах шаардлагатай
- Одоо 2 хүлэмжинд тарилт хийдэг. Нэмж 2-3 хүлэмж барих шаардлагатай
- Хүний нөөц мууттай. Сум дундын ой анги 3 хүнтэй ажиллаж байнаӨвлийн хүлэмж барих санал төслийн нэгжид хүргүүлсэн.
- Нэмээд 2-3 хүлэмж барих шаардлага байгаа. Орон нутагт ажлын байр шинээр бий болно.
- Сургалт зохион байгуулах хэрэгтэй байна.

## 5.4 КЛАСТЕР-I БҮС НУТГИЙН ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ, МОД, МОДЛОГ НӨӨЦИЙГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүснэгт 40. Хэрэгжүүлэх төслийн санал

1. КЛАСТЕР –I: БҮС НУТГИЙН ТХГН-Т ХЭРЭГЖҮҮЛЭХ ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭТЭЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ		
1.1. Ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолт явуулах машин, технологийн зүгшрүүлэлт, нутагшуулалтын туршилт, судалгааны төсөл		
Үе шат	Үр дүн	Ач холбогдол
<p>1.Ойд арчилгааны (сийрэгжүүлэх, завсрын, гэрэлжүүлэх, тохируулах) огтлолтын иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт судалгаа.</p> <p>2.Ойн цэвэрлэгээний иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт, судалгаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Шигүү ургасан зулзган, залуу ойд тохирсон арчилгаа, цэвэрлэгээний огтлолт явуулах технологийн схем (карт)-ийг боловсруулна.</li> <li>• Энэхүү технологийн схемд нийцүүлэн технологийн ажилбарыг гүйцэтгэх машин, багаж хэрэгслийн судалгаа явуулж, зүгшрүүлэлт, туршилт судалгаа явуулж, машин багаж хэрэгслийн сонголт хийнэ.</li> </ul>	<p>Экологийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шигүү ургаж буй модны ургах орчин сайжирч залуу ойн амьдрах чадвар дээшилнэ.</li> <li>- Ойн орчин эрүүлжиж, ойд хөнөөлт шавж, түймэр тархах эрчим буурна.</li> </ul> <p>Эдийн засгийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн ойн таваарлаг чанар дээшилнэ</li> <li>- Орчны бүсийн мод, модон материалын түүхий эдийн хангалт нэмэгдэнэ.</li> </ul> <p>Нийгмийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ойн аж ахуйн арга хэмжээ явуулах зорилго, зорилтууд тодорхой болно.</li> <li>- Ойн арчилгаа, цэвэрлэгээний огтлолтын сургалт, судалгаа явуулах бодит орчин бүрдэнэ.</li> </ul>
1.2. Ойн өндөр хожуул огтлолтын машин, технологийн зүгшрүүлэлт, нутагшуулалтын туршилт, судалгааны төсөл		
Өндөр хожуул огтлолтын иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт судалгаа	<ul style="list-style-type: none"> <li>• Өндөр хожуулын огтлолт явуулах технологийн схем (карт)-ийг боловсруулна.</li> <li>• Технологийн схемд нийцүүлэн технологийн ажилбарыг гүйцэтгэх машин, багаж хэрэгслийн судалгаа явуулж, зүгшрүүлэлт, туршилт судалгаа явуулж, машин багаж хэрэгслийн сонголт хийнэ.</li> </ul>	<p>Экологийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өндөр хожуулыг авснаар модны ургах орчин сайжирч залуу ойн амьдрах чадвар дээшилнэ.</li> <li>- Ойн орчин эрүүлжинэ</li> </ul> <p>Эдийн засгийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орчны бүсийн иргэдийн түлшний модны хэрэгцээний хангалт нэмэгдэнэ.</li> </ul> <p>Нийгмийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ОМБ-ын техник технологи сайжирна</li> </ul>
1.3. Бүс нутгийн онцлогт тохируулж мод үржүүлгийн газар байгуулах төсөл		

<p>Бортогонд тарьц,суулгац ургуулах механикжсан технологийг нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Шилмүүст модны тарьцыг уламжлалт технологийн дагуу хүлэмжинд үрээр тариалж нэг настай тарьц ургуулж</li> <li>• Хоёр болон түүнээс дээш настай тарьцыг бортогонд шилжүүлэн суулгаж, ургуулах ажлыг механикжуулах технологийн судалгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тарьцыг бортогонд шилжүүлэн суулгах технологи хөгжүүлснээр ойжуулалтын ажлын улирлын хамаарлыг багасна</li> <li>- Суулгацын амьдралтын хувь дээшилнэ</li> <li>- Нэгж талбайгаас ургуулж авах тарьцны тоо олон болно</li> <li>- Шилмүүст модны үрийг бортогонд тарьж ургуулах болон тарьцыг бортогонд шилжүүлэн суулгах технологи хөгжүүлснээр мод үржүүлгийн ажилчдын ажлын байрны нөхцөл эрс сайжирна</li> </ul>
<p><b>2. КЛАСТЕР –I: БҮС НУТГИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ</b></p>		
<p><b>2.1. Сургалт, сурталчилгааны ажлыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах төсөл</b></p>		
<p>1. Ойн анги, ОМБ болон ойн нөхрлөлүүдэд зориулсан чадавхжуулах сургалт 2. Орчны бүсийн иргэд, малчидад зориулсан мэдлэг, мэдээлэл өгөх сургалт 3. Хүүхэд, залуучуудад зориулсан экологийн боловсрол олгох сургалт</p>	<p>1-р сургалтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• мэргэжил аргагүйн сургалт</li> <li>• шинэ техник технологи, инновацийн туршлага судлуулах</li> <li>• газарзүйн мэдээллийн сангийн талаар</li> </ul> <p>2, 3-р сургалтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• ТХГН-ийн тухай хууль, журам</li> <li>• Биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдол</li> <li>• Уур амьсгалын өөрчлөлтийн талаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойн анги, ОМБ-ын хүний нөөцийн чадавхи сайжирна</li> <li>- Ойн нөхөрлөлүүд ойн нөөцийг хамгаалах менежментийг зөв зохион байгуулна</li> <li>- Модыг оновчтой ашиглах талаар орчны бүсэд амьдарч буй иргэдийн мэдлэг, ухамсар дээшилнэ.</li> <li>- ТХГН-ын хамгаалалтын захиргаа иргэд хооронд гардаг зөрчил багасна.</li> <li>- Байгаль хамгаалах ажилд оролцох оролцоо нэмэгдэнэ</li> <li>- Залуу үе байгаль орчинтой зөв харьцах</li> <li>- Байгаль орчны чиглэлээр мэргэжил сонгох сонирхол нэмэгдэнэ</li> </ul>
<p><b>3. КЛАСТЕР –I: БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ</b></p>		
<p><b>3.1. Модлог био түлш үйлдвэрлэх технологийн төсөл</b></p>		
<p>Доройтсон ойн үхмэл мод болон зүсмэлийн үйлдвэрийн үлдэц модоор шахмал биотүлш үйлдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Модлог био түлш үйлдвэрлэх технологийг боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх</li> </ul>	<p>Доройтсон ойн үхмэл модны нөөцийг үйлдвэрлэл-эдийн засгийн эргэлтэд оруулан биотүлш үйлдвэрлэн Клатер-III бүс нутгийн болон баруун бүсийн ойн нөөц багатай сумуудын түлшний хэрэгцээнд хэрэглэж хэвшүүлэх өндөр ач холбогдолтой</p>

## 5.2. КЛАСТЕР- II БҮС НУТГИЙН ТХГҮ-ИЙН ОРЧНИЙ БҮСИЙН СУМУУДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 5.2.1. ХОВД АЙМГИЙН БУЛГАН, БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Ховд аймгийн Булган сум (Булган гол – Их Онгогийн БЦГ):** Улаанбаатар хотоос 1855 км, Аймгийн төвөөс 387км зайд байрладаг. Монгол Улсын баруун хязгаар, баруун талаараа БНХАУ, хойд талаараа Баян-Өлгий аймгийн Булган сум, зүүн ба өмнөд талаараа Ховд аймгийн Үенч сумтай хиллэдэг. Хилийн 2 боомттой. Монгол Алтайн нурууны зүүн хэсэг говь, хангай хосолсон үзэсгэлэнт байгальтай ховор, нэн ховор ан амьтан, ургамалтай. Ярант боомт нь сумын төвөөс 45 км-т байдаг бөгөөд байнгын ажиллагаатай, Байтаг боомт сумаас 130 км-т улирлын чанартай ажилладаг. Далайн түвшнээс дээш 1172-3501м өргөгдсөн. Булган голын хөндий нь тэгш тал намгархаг голын сав газар болно. Сумын нутаг дэвсгэр нь Монгол Алтайн нуруу, уул, гүвээ толгод бүхий тал хээр, голын сав, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Засаг захиргааны таван багтай, 2460 өрх 9807 хүн амтай Монгол улсын тэргүүний сум.

**Баян-Өлгий аймгийн Булган сум (Мөнххайрхан уулын БЦГ):** Баян-Өлгий аймгийн өмнө хэсэгт Улаанбаатар хотоос 2000 км, аймгийнхаа төвөөс 300 км зайд байрладаг. Баян-Өлгий аймгийн хамгийн урд захад хойноос урагш сунаж тогтсон байрлалтай, баруун талаараа 150 км БНХАУ-тай хиллэдэг, урд хэсгээрээ Ховд аймгийн Булган, Үенч, зүүн талаараа Мөнххайрхан, зүүн хойд талаараа Дуут, хойд талаараа өөрийн аймгийн Дэлүүн сумтай тус тус хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1500-4362 өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Алтай нурууны ноёлох өндөрлөг Мөнххайрханы баруун талын өндөр уулын бүсэд оршдог. Нийт газар нутгийн хэмжээ 497700 га. Булган гол нь сумын хойт хилээс эх авч олон жижиг голуудаар тэжээгдэн нутгийн дундуур 130 км урсч Ховд аймгийн Булган сумын нутагруу нэвтэрч урсдаг. Усалгаатай газар тариалан эрхлэх боломжтой.

*Хүснэгт 41. Сумын хүн ам болон малын тоо*


Аймгийн нэр	Сумын нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо	Малын тоо \төрлөөр\				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Ховд	Булган	2460	9807	2331	13245	36792	66724	195561
Баян-Өлгий	Булган	1298	5686	592	7501	13053	26022	84420

## 5.2.2. ОЙН НӨӨЦ, ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА


Кластер-II бүс нутгийн Булган гол – Их Онгогийн БЦГ –ын орчны бүсийн Ховд аймгийн Булган, Мөнххайрхан уулын БЦГ-ын орчны бүсийн Баян-Өлгий аймгийн Булган сумуудын ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын талаар дүн шинжилгээ хийхийн тулд ойн төлөв байдал, ойн менежментэд тулгарч буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, ойн менежментийн ороцогч талуудын саналыг оролцооны аргаар тодорхойлж авсан.



Зураг 39. Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Булган сумын оролцогч талуудтай хийсэн уулзалт



Зураг 40. Оролцооны аргаар зурагласан зураг



*Зураг 41. Шигүү ургасан залуу ой болон ойн захгаар тэлж ургаж байгаа зулзган модыг мал идсэн байдал*



*Зураг 42. Нарийн шургаагийг байшин барих, хашааны шон хийхэд ашигласан байдал*



Зураг 43. Түлшинд хэрэглэдэг хатсан, унасан мод, мөчир гишүү



Зураг 44. Таримал жимсний плантаци

Хүснэгт 42. Класер-II: ойн аж ахуйн арга хэмжээ

№	Аж ахуйн арга хэмжээ, га	Кластер II
1	Арчилгааны огтлолт	935
		13684
2	Цэвэрлэгээний огтлолт	-
		-
3	Ойжуулалт	81
4	БСУ туслах	-
5	Самар түүх	-
6	Жимс түүх	-
7	Өндөр хожуулыг тайрах	-
<b>Кластерийн дүн</b>		<b>1016</b>
		<b>13684</b>

Хүснэгт 42-д төлөвлөгдсөн ойн аж ахуйн арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлснээр ойн орчин, байгалийн сэргэн ургалт сайжирч, модлогийн чанар дээшилнэ. Арчилгааны огтлолтоос гарах модыг авч ашиглах боломжтой. Судалгаанд хамрагдсан нийт нутгийн хэмжээгээр 1016 га ойгоос 13684 м<sup>3</sup> нөөц бүхий модлог авч ашиглах боломжтой байна.



Хүснэгт 43. Ойгоос олж байгаа орлого

<b>Ховд аймгийн Булган сум</b>		
Сумын ойн анги	Байхгүй ( .....	
ОМБ	Байхгүй	
Нөхөрлөл		
	Эзэмшлийн талбай,	
Сумын татварын нийт орлого /төг/:		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр		
Байгалын ургамлын нөөц ашигласны		
Ойн нөөц ашигласны төлбөр		
Модны хэрэгцээ		
Түлшний модны хэрэгцээ	2460 өрх (2-3 м <sup>3</sup> )	
Хэрэгцээний мод	-	
Мужааны жижиг цех	Байхгүй	
<b>Баян-Өлгий аймгийн Булган сум</b>		
Сумын ойн анги	Байхгүй ( .....	
ОМБ	Байхгүй	
Нөхөрлөл	8 (байгаль хамгаалах чиглэлээр )	288 хүн
	Эзэмшлийн талбай, га -	
Сумын татварын нийт орлого /төг/: 178.000.000		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр		
Байгалын ургамлын нөөц ашигласны		
Ойн нөөц ашигласны төлбөр		
3.793.000		
Модны хэрэгцээ		
Түлшний модны хэрэгцээ	2460 өрх (2 - 3 м <sup>3</sup> )	200 м <sup>3</sup>
Хэрэгцээний мод	-	
Мужааны жижиг цех	Байхгүй	

### 5.2.3. SWOT ДҮН ШИНЖИЛГЭЭ

Кластер – II бүс нутагийн Булган гол – Их Онгогийн БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ-ын орчны бүс нутагт хамрагдах Ховдын Булган, Баян-Өлгийн Булган сумдын ойн нөөц болон ойн дагалт баялаг ашиглалтын төлөв байдлад SWOT шинжилгээг орон нутгийн оролцогч талуудаас гаргасан саналыг тусгасан хувилбараар үзүүлэв.

Хүснэгт 44. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Ойн нөөц багатай учраас ойн түмэр, хортон шавжний хөнөөл багатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алслагдмал</li> <li>Ойн нөөц бага</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Доройтсон ойн нөөц байхгүй</li> <li>• Ойгоос хамаарал багатай амьдардаг</li> <li>• Ойн бус материал ашиглаж сурсан (чулуугууар хашаа, хороо барьдаг)</li> <li>• Аргал, хөрзөн, нүүрс түлдэг</li> <li>• Голын цагаан бургасны нөөцтэй</li> <li>• Цагаан бургасаар гэрийн мод хийдэг туршлагатай, уламжилж ирсэн</li> <li>• Нутгийн иргэд жимс, жимсгэний аж ахуй эрхлэж, орлогын эх үүсвэр болгодог туршлагатай</li> <li>• Хөрс ургамал ургах таатай нөхцөлтэй, ургамал ургах хугацаа урт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Модон бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь бусад аймгуудаас хангадаг</li> <li>• Ойн арчилгааны огтлолт хийдэггүй, ой нь маш шигүү, чанар муутай</li> <li>• Ойн менежмент, ойн аж ахуйн чиглэлээр ажиллах мэргэшсэн боловсон хүчин цөөхөн</li> <li>• Мал ойн захаар их бэлчээрэлдэг нөхцлөөс шалтгаалан ойн байгалийн тэлж ургах боломж муутай</li> <li>• Модыг тармилжуулах, нөхөн сэргээх туршлага муутай</li> <li>• Ойн дагалт баялагийн нөөц байтай</li> <li>• Ховор ургамлын нэр төрөл олонч нөөц багатай</li> </ul>
<p><b>Боломж</b></p>	<p><b>Эрсдэл аюул</b></p>
<ul style="list-style-type: none"> <li>• Арчилгааны огтлолыг үе шаттайгаар хийснээр модны өсөлт, ойн экологийн байдал сайжирах,</li> <li>• Арчилгаанаас гарсан нарийн модыг хашаа, саравч, түлшинд ашиглах,</li> <li>• МҮГ байгуулан цагаан бургас болон бүс нутагт тохирсон модны төрөл зүйлийг тармилжуулах, ойжуулах</li> <li>• Голын татмын цагаан бургасыг шинжлэх ухааны үндэслэлтэй тайрч, огтлолт хийх,</li> <li>• Цагаан бургасыг тарималжуулах замаар гэрийн мод хийдэг уламжлалыг сэргээх, хөгжүүлэх</li> <li>• Жимс, жимсгэнэ, хүнсний ногооний талбайг салхи, элсний нүүдлээс хамгаалах зорилгоор цагаан бургасаар хамгаалалтын зурвас байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ойд арчилгааны огтлолт хийдэггүйгээс ойн экологийн ач холбогдол буурна</li> <li>• Арчилгааны огтлолтоос гарах модыг авч ашиглаж чаддаггүй</li> <li>• Ойн мэргэжлийн байгууллага байдаггүй</li> <li>• “Бор хог” нэрээр авч ашигласнаар цагаан бургасны нөөц багасаж байгаа</li> <li>• Голын цагаан бургасыг авч ашиглахыг хориглосноос гэр хийдэг уламжлал алдагдах</li> <li>• Ховор ургамлын нөөц багатай учраас түүж ашиглавал устах аюултай</li> </ul>

➤ **ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

- Мөнхайрхан уулын хамгаалалтын захиргаа өнгөрсөн жилүүдэд арчилгааны огтлолт хийлгүүлэх саналаа БОАЖЯ-д хүргүүлдэг боловч төлөвлөгөөнд тусгуулж чаддаггүй
- Зуслангийн газар гэдэг нэртэй ойд хүчтэй салхинд унасан шинэс мод их байдаг авч ашиглаж чаддаггүй
- Түлшний гол эх үүсвэр нүүрс, аргал юм. Нутгийн иргэд гал асаах нүүрс түлэхийн өмнө “бор хог” гэж нэрлэдэг хуурай, унасан бургасыг түлшинд ашигладаг байсан. Гэвч Булган голыг хамгаалалтанд авснаар “бор хог” гэж нэрлэдэг хуурай, унасан бургасыг авч чадахаа больсон. Энэ байдал сумын иргэд, цагдаа, нарын хооронд зөрчил их үүсдэг.

- Орчны бүсэд малчид өвөлжөө, хаваржааны газраа өмчилж авах талаар ТХГН-ын хамгаалалтын захиргаанд хүсэлт их гаргадаг
- Орчны бүсэд амьдардаг иргэд ТХГН-ын тухай хууль, журмын талаар ойлголт багатай
- Нутгийг иргэд хязгаарлалтын бүс болон орчны бүсэд хадлангийн талбай тор ихээр татсан
- ТХГН-ын хамгаалалтын үйл ажиллагаа орон нутгийн зарим үйл ажиллагаатай зөрчилддөг

➤ **ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛ:**

- Булган голын цагаан бургасыг хамгаалах, өсгөх зорилгоор цагаан бургасны мод үржүүлгийн газар байгуулах төсөл
- Булган голын хатсан, унасан бургас болох “бор хог”-ыг авч зүй зохистой авч ашиглах
- Зуслангийн газар гэдэг нэртэй ойд хүчтэй салхинд унасан шинэс модыг сумын зорилтот бүлгийн өрхд (75 дээш настай, эмзэг бүлгийн өрх) түлшний модны зориулалтаар бэлдэх
- Жимс, хүнсий ногоо тариайлдаг талбайг салхинаас хамгаалах зорилгоор цагаан бургасаар хамгаалалтын зурвас байгуулах
- Сайн чанарын жимсний сортууд авахад дэмжих
- Цүнхэл нуур орчим “Мод үржүүлгийн газар байгуулах төсөл” хэрэгжүүлэх. Орон нутгаас хашааны тор авах санхүүжилтийг шийдэж өгсөн. Сумын төвөөс 80 км, 30 га газар.
- Хогийг дахин боловсруулах цех, үйлдвэр барих мод орлох материал хийх
- “Нуман тамагт” хоршоо 3.5 га газар 2013 оноос чацарганы үржүүлэг байгуулсан. Одоогоор жилд 6-7 тн чацарган хураадаг. Хадгалах хүндрэлтэй. Өтгөрүүлсэн шүүс гаргах цех байгуулах төслийг дэмжих
- Хязгаарлалтын бүс болон орчны бүсэд хадлангийн талбай тор татаж тусгаарлахыг буулгах арга хэмжээ

**5.2.4. КЛАСТЕР-II БҮС НУТГИЙН ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ, МОД, МОДЛОГ НӨӨЦИЙГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ**

Хүснэгт 45. Хэрэгжүүлэх төслийн санал

1. КЛАСТЕР –II БҮС НУТГИЙН ТХГН-Т ХЭРЭГЖҮҮЛЭХ ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭТЭЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ		
1.1 Ойд арчилгааны огтлолт явуулах машин, технологийн зүгшрүүлэлт, нутагшуулалтын туршилт, судалгааны төсөл		
Үе шат	Үр дүн	Ач холбогдол
1-р үе шат: Зулзан ойд гэрэлжүүлэх, тохируулах огтлолтын иж бүрэн машин,	<ul style="list-style-type: none"> <li>• Кластер–II бүс нутгийн ТХГН-т ойн ургалтын онцлог нөхцөлд ургасан</li> </ul>	Экологийн ач холбогдол нь: <ul style="list-style-type: none"> <li>- Шигүү ургаж буй модны ургах орчин сайжирч залуу ойн амьдрах чадвар дээшилнэ.</li> </ul>

<p>технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт судалгаа.</p> <p>2-р үе шат: Ойд арчилгааны сийрэгжүүлэх болон завсрын огтлолтын иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт, судалгаа</p>	<p>зулзган, залуу ойд тохирсон арчилгааны огтлолт явуулах технологийн схем (карт)-ийг боловсруулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Энэхүү технологийн схемд нийцүүлэн технологийн ажилбарыг гүйцэтгэх машин, багаж хэрэгслийн судалгаа явуулж, зүгшрүүлэлт, туршилт судалгаа явуулж, машин багаж хэрэгслийн сонголт хийнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Шигүү ургаж буй модны ургах орчин сайжирч залуу ойн амьдрах чадвар дээшилнэ.</li> </ul> <p>Эдийн засгийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн ойн товарлаг чанар дээшилнэ</li> <li>- Орчны бүсийн мод, модон материалын түүхий эдийн хангалт нэмэгдэнэ.</li> </ul> <p>Нийгмийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Модыг оновчтой ашиглах талаар орчны бүсэд амьдарч буй иргэдийн мэдлэг, ухамсар дээшилнэ.</li> <li>- Ойн аж ахуйн арга хэмжээ явуулах зорилго, зорилтууд тодорхой болно.</li> <li>- Ойн аричлгааны огтлолтын сургалт, судалгаа явуулах бодит орчин бүрдэнэ.</li> </ul>
<p>1.2 Мод үржүүлгийн плантаци байгуулах төсөл</p>		
<p><b>2. КЛАСТЕР –II БҮС НУТГИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b></p>		
<p>2.1 Булган голын цагаан бургасыг хамгаалах, өсгөх зорилгоор цагаан бургасны мод үржүүлгийн газар байгуулах төсөл</p>		
<p>2.2. Сургалт, сурталчилгааны ажлыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах төсөл</p>		

	<p>3 Ойн анги, ОМБ болон ойн нөхөрлөлүүдэд зориулсан чадавхжуулах сургалт</p> <p>4 Орчны бүсийн иргэд, малчидад зориулсан мэдлэг, мэдээлэл өгөх сургалт</p> <p>5 Хүүхэд, залуучуудад зориулсан экологийн боловсрол олгох сургалт</p>	<p>1-р сургалтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• мэргэжил аргагүйн сургалт</li> <li>• шинэ техник технологи, инновацийн туршлага судлуулах</li> <li>• газарзүйн мэдээллийн сангийн талаар</li> </ul> <p>2, 3-р сургалтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• ТХГН-ийн тухай хууль, журам</li> <li>• Биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдол</li> <li>• Уур амьсгалын өөрчлөлтийн талаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойн анги, ОМБ-ын хүний нөөцийн чадавхи сайжирна</li> <li>- Ойн нөхөрлөлүүд ойн нөөцийг хамгаалах менежментийг зөв зохион байгуулна</li> <li>- Модыг оновчтой ашиглах талаар орчны бүсэд амьдарч буй иргэдийн мэдлэг, ухамсар дээшилнэ.</li> <li>- ТХГН-ын хамгаалалтын захиргаа иргэд хооронд гардаг зөрчил багасна.</li> <li>- Байгаль хамгаалах ажилд оролцох оролцоо нэмэгдэнэ</li> <li>- Залуу үе байгаль орчинтой зөв харьцах</li> <li>- Байгаль орчны чиглэлээр мэргэжил сонгох сонирхол нэмэгдэнэ</li> </ul>
	<p>2.3. <b>Таримал жимс, жимсгэний өтгөрүүлсэн шүүс гарган авах цехийн төсөл</b></p>		
	<p><b>3. КЛАСТЕР –II БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ</b></p>		

### 5.3. КЛАСТЕР-III БҮС НУТГИЙН ТХГН-ЫН ОРЧНЫ БҮСИЙН СУМУУДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### 5.3.1. УВС АЙМГИЙН ӨНДӨРХАНГАЙ, ЗҮҮНХАНГАЙ, ЦАГААНХАЙРХАН СУМДЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Өндөрхангай сум:** Өндөрхангай сум нь хойд талаараа Баруунтуруун сумтай 51.8 км, зүүн талаараа Зүүнхангай сумтай 96.5 км, баруун талаараа Цагаанхайрхан сумтай 98.8 км, өмнөд талаараа Завхан аймгийн Сантмаргаз сумтай 45.8 км, Ургамал сумтай 4.4 км-ээр тус тус хиллэнэ. Сумын нутаг нь д.т.дээш дунджаар 2000 метрийн өндөрт орших бөгөөд нийт талбайн хэмжээ 470647 га юм. Улаанбаатар хотоос 1130 км, аймгийн төвөөс 286 км зайтай оршино. 5 багтайгаас Цалуу, Жаргалант, Цэцэрлэг багуудын нутагт тус БЦГ нь хамрагддаг. Сумын нутгийн төв хэсгээр Хан-Хөхийн нурууны гол өндөрлөгүүд оршино. Тус сум нь 865 өрх, 3219 хүн амтайгаас 61 хувийг хөдөлмөрийн насны хүн, 0-18 насны хүүхэд 36 хувийг эзэлдэг. Өндөрхангай сум нь хүн амын нягтшил нь 0,7 байна.

**Зүүнхангай сум:** Хан Хөхийн нурууны зүүн төгсгөлийн хэсэгт байрладаг. Баруун талаараа Өндөрхангай сум, хойд талаараа Баруунтуруун сум, зүүн талаараа Завхан аймгийн Тэс, Баянхайрхан, Сонгино сумдтай, өмнө талаасаа Завхан аймгийн Сантмаргац сумтай тус тус хил залган оршдог. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 2,6 мянга км<sup>2</sup>. Улаанбаатар хотоос 1080 км зайд, Увс аймгийн төв Улаангом хотоос 360 км зайд оршдог. Нийт 640 өрх, 2353 хүн амтай. 1905 оны газар хөдлөлтийн ул мөр болох Ханхөхий-Булнайн хагарал Зүүнхангай сумын нутгийг таллан хуваадаг. Хойд хэсгээрээ ой уулархаг, өмнөд хэсгээрээ талархаг газрын гадаргатай. Тус сумын 39 хувь нь Хан Хөхийн нурууны БЦГ-т хамрагддаг.

**Цагаанхайрхан сум:** Улаанбаатар хотоос 1190 км, аймгийн төвөөс 226 км зайтай оршдог. 4 багтай бөгөөд тэдгээрээс 1, 2, 3-р багийн нутаг тус БЦГ-ын нутаг дэвсгэрт харьяалагддаг. Нийт 2094 хүн амтай. Газар нутгийн хэмжээ нь 399,4 мянган га талбайг хамрах бөгөөд Хяргас, Зүүнговь, Баруунтуруун, Өндөрхангай, Завхан сумдтай болон Завхан аймгийн Ургамал сумтай хиллэнэ. Тус сумын 9 хувь нь БЦГ-т хамрагддаг.

Хан Хөхий нурууны БЦГ –ын орчны бүсийн бүх сумууд баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Хөдөөгийн малчид 100 хувь нарны жижиг оврын цахилгаан эх үүсгүүртэй. Байгалын Цогцолборт газарт хамрагдах сумдад дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, аймгийн төвтэй шууд хатуу хучилттай замаар холбогдоогүй ч Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумын нутгаар Улаангом Тосонцэнгэлийг холбосон зам дайран өнгөрдөг. Хан Хөхий нуруу нь Хангайн нурууны баруун талын бие даасан томоохон салбар уулс юм. газрутаг дэвсгэрийн ихэнх нь 2600 – 2800 метр өргөгдсөн уулархаг тогтолцоотой, ой модоор хучигдсан,


уулс хоорондын хөндийгөөр тэгш талархаг гадаргатай. Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумдын нутагт газар тариалан эрхлэхэд тохиромжгүй. Малын бэлчээр сайтай тул мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой.

Хүснэгт 46. Сумын хүн ам болон малын тоо

Аймгийн нэр	Сумын нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо	Малын тоо \төрлөөр\				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Увс	Өндөрхангай	865	3219	403	12771	15631	113451	105046
	Зүүнхангай	640	2353	157	11306	11552	95687	67284
	Цагаанхайрхан	557	950	422	7154	6341	80216	91096

### 5.3.2. КЛАСТЕР-III. ОЙН НӨӨЦ, ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

Кластер–III бүс нутгийн Хан Хөхий нурууны БЦГ-ын орчны бүсийн Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумуудын ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын талаар дүн шинжилгээ хийхийн тулд ойн төлөв байдал, ойн менежментэд тулгарч буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, ойн менежментийн оролцогч талуудын саналыг оролцооны аргаар тодорхойлж авсан.



Зураг 45. Оролцооны аргаар зураглал хийж буй байдал

Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сумын ойн сангийн талбайн

78421 га талбай Кластер –III бүс нутгийн “Хан Хөхий нурууны БЦГ”-т хамрагдаж байна

- 196 хэсэглэл
- 4994 ялгарал

Хүснэгт 47. Кластер-III: ойн аж ахуйн арга хэмжээ

№	Аж ахуйн арга хэмжээ, га	Кластер III
	Арчилгааны огтлолт	2696
		45935
2	Цэвэрлэгээний огтлолт	4447
		132053
3	Ойжуулалт	1957
4	БСУ туслах	1123
5	Самар түүх	1170
6	Жимс түүх	1199
7	Өндөр хожуулыг тайрах	8419
		8400
<b>Кластерийн дүн</b>		<b>21021</b>
		<b>186388</b>

Дээрх хүснэгтэнд төлөвлөгдсөн ойн аж ахуйн арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлснээр ойн орчин, байгалийн сэргэн ургалт сайжирч, модлогийн чанар дээшилнэ. Арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоос гарах модыг авч ашиглах боломжтой. Судалгаанд хамрагдсан нийт нутгийн хэмжээгээр 21021 га ойгоос 186388 м<sup>3</sup> нөөц бүхий модлог авч ашиглах боломжтой байна.



Зураг 46. Зүсвэрийн хөрөө рамаас гарсан үртэс, зоргодсыг хог дээр хаяхаар ачааны машинд ачсан байдал



Хүснэгт 48. Ойгоос олж байгаа орлого

<b>Увс аймгийн Өндөрхангай сум</b>		
Сумын ойн анги	Сум дундын ойн ангитай (Цагаанхайрхан, Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай)	
ОМБ	1 (10 хүн)	
Нөхөрлөл	Ойн нөхөрлөл - 5	45 хүн
	Эзэмшлийн талбай, га - 3365 га хариуцуулдаг	
Сумын татварын нийт орлого /төг/: 2020, 2021,		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	-	
Байгалын ургамлын нөөц ашигласны	-	
Ойн нөөц ашигласны төлбөр	/26,142,040.00/, /55,000.000/	
<b>Модны хэрэгцээ</b>		
Түлшний модны хэрэгцээ	865 өрх (8 м <sup>3</sup> )	3200 м <sup>3</sup> Дарц, гишүү- 600 м <sup>3</sup>
Хэрэглээний мод	1600 м <sup>3</sup>	
Мужааны жижиг цех	Байхгүй	
Хөрөөө рам	5 (20 хүн ажиллагаг)	
<b>Увс аймгийн Зүүнхангай сум</b>		
Сумын ойн анги	Байхгүй (Өндөрхангай сум дундын ойн анги хариуцдаг)	
ОМБ	1	15 хүн ажилладаг
Нөхөрлөл	2	40 хүн
	Эзэмшлийн талбай, га – 165 га хариуцуулдаг	
Сумын татварын нийт орлого /төг/: 2020 он, 2021 он		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	-	
Байгалын ургамлын нөөц ашигласны	-	
Ойн нөөц ашигласны төлбөр	(10,315,500.00) (18,798,275.00)	
<b>Модны хэрэгцээ</b>		
Түлшний модны хэрэгцээ	641 өрх (8 м <sup>3</sup> )	1800 м <sup>3</sup>
Хэрэглээний мод	500 м <sup>3</sup>	
Мужааны жижиг цех - 1	3 хүн ажилдаг Сумын дотоод хэрэгцээний гэр ахуйн тавилга хийдэг	
<b>Увс аймгийн Цагаан хайрхан сум 2020 он, 2021 он</b>		
Сумын ойн анги	Байхгүй (Өндөрхангайн сум дундын ойн анги хариуцдаг)	
ОМБ	1	15 хүн
Нөхөрлөл	3	42 хүн
	Эзэмшлийн талбай, га - 2820 га хариуцуулдаг	
Сумын татварын нийт орлого /төг/: 2020 он, 2021 он		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	-	
Байгалын ургамлын нөөц ашигласны	-	
Ойн нөөц ашигласны төлбөр	(6.393,937.67), (22,336,190.00)	
<b>Модны хэрэгцээ</b>		

Түлшний модны хэрэгцээ	550 өрх	1350м <sup>3</sup> мод бэлтгэнэ
Хэрэглээний мод	620 м <sup>3</sup>	
Мужааны жижиг цех - 1	Сумын дотоод хэрэгцээний гэр ахуйн тавилга хийдэг.	

### 5.3.3. SWOT ДҮН ШИНЖИЛГЭЭ

Кластер- III бүс нутгийн Хан Хөхий нурууны БЦГ –ын орчны бүсд хамрагдах сумдын ойн нөөц болон дагалт баялаг ашиглалтын төлөв байдлад SWOT шинжилгээг орон нутгийн оролцогч талуудаас гаргасан саналыг тусгасан хувилбараар үзүүлэв.

Хүснэгт 49. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Ойн нөөцтэй</li> <li>• Хуш модны тархалт ихтэй</li> <li>• ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, орон нутаг ойн нөөцөө хамгаалахад ихээхэн анхаардаг</li> <li>• ТХГН-ын орчны бүсийн ойн сангийн мэдээлэл болон ойн зохион байгуулалт хийгдсэн</li> <li>• Ойн аж ахуйн болон мод боловсруулах чиглэлийн мэргэжилтэнтэй</li> <li>• Дэд бүтэц хөгжсөн</li> <li>• Ахуйн хэрэглээний модон тавилга хийдэг цехтэй</li> <li>• Гэр ахуйн тавилга хийдэг цех ЖДҮ-ээс зээл аваад орон нутгаас дэмжээд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг болсон зах зээлээ дагаад хэрэглэгчидтэй болсон</li> <li>• Зүсвэрийн хөрөө рам ажилладаг</li> <li>• Үхрийн нүд, гүзээлзгэнэ, аньс, чонын элэг зэрэг жимсний нөөц ихтэй</li> <li>• Хэрэглээний зориулалтаар -500 м<sup>3</sup></li> <li>• Түлшний зориулалтаар -700 м<sup>3</sup></li> <li>• Бүс нутгийн онцлогт тохирсон МҮГ байгуулах саналыг орон нутгаас дэмжиж байгаа</li> <li>• Орчны бүсийн сумуудын ороцогч талууд орчин үеийн технологи нэвтрүүлж үхмэл модны нөөцөө ашиглах хүсэл зорилготой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ойн нөөцийн модны таваарлаг чанар муудсан</li> <li>• Байгалийн сэргэн ургалт маш шигүү</li> <li>• Завхан аймгийн хил, залгаа сумууд нь ойн нөөц муутай сумууд байдаг учраас хууль бусаар мод бэлтгэдэг</li> <li>• Мэдээлэл, өгөгдөл нийцэл муу</li> <li>• Мод бэлтгэлийн үйлдвэр байх үед хавтгайруулан огтолсон газар нилэнхүүдээ хатсан хожуулууд ихтэй</li> <li>• Хожуул болон унасан, босоо хатсан модыг ашиглаж чаддаггүй</li> <li>• Одоо хэрэглэж байгаа техникээр хүрч, авах боломжтой таваарлаг чанар өндөртэй моднуудыг аваад дууссан</li> <li>• ОМБ-ын Техник, технологи хоцрогдсон.</li> <li>• Орчны бүсэд байгалийн зарим ургамлыг эмчилгээний болон ахуйн хэрэглээний зориулалтаар ашигладаг боловч зах зээл дээр борлуулж өрхийн оролгыг нэмэгдүүлэх туршлага байдаггүй.</li> <li>• Жимсний нөөцтэй боловч боловсруулах цех байдаггүй учраас ахуйн хэрэгцээний зориулалтаар түүдэг.</li> <li>• Модны мөчир гишүүг түлшинд хэрэглэдэггүй, авч ашигладаггүй</li> <li>• Хөрөө рамаас гардаг үртэс, зомголыг хог дээр хаядаг</li> <li>• Самарын нөөц багатай үйлдэрийн зориулалтаар түүдэггүй</li> <li>• Жимсний нөөц ихтэй боловч боловсруулах цех байхгүй учраас орон</li> </ul>

	<p>нутгийн иргэд өрхийн хэрэгцээнд түүж иддэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ойн дагалт баялагаас орлого олохдоо муу, туршлага байхгүй</li> <li>• Иргэдийн экологийн мэдлэг боловсрол дутмаг (хууль эрх зүй)</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Эрсдэл аюул</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн засаг захиргаа, ТХГН-ын хамгаалалтын захиргаа, ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүд илүү ихийг хийх зорилт, төлөвлөгөөтэй</li> <li>• Хожуул, мөчрийг авч ашиглдаг технологи, тоног төхөөрөмжийг орон нутагт нэвтрүүлж түлшинд ашиглах,</li> <li>• Авсан хожуулын оронд тарьц суулаж ойжуулах нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх</li> <li>• МҮГ-ыг бүсчлсэн хэлбэрээр чадавхийг бэхжүүлэх</li> <li>• Орон нутгийн түлшний хэрэгцээг 10-20 жил хангах хожуулын нөөц бий</li> <li>• Байгалийн жимс боловсруулах цех байвал нутгийн иргэд ойгоос түүгээд өгөөд байх бүрэн боломжтой. тодорхой орлого олох боломжтой.</li> <li>• Зүсмэлийн рамаас гарч байгаа үртэсийг шахмал түлш хийж ашиглах</li> <li>• Доройтсон ойн үхмэл модыг ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх</li> <li>• Тоног төхөөрөмжийг нийлүүлэх, сургалт семинар явуулах хэрэгцээ шаардлаг маш их хэрэгтэй байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний хүчин зүлээс гадна байгалийн хүчин зүйл (ойн түймэр, хортон) ойн нөөцийг их доройтуулах аюултай</li> <li>• Орчны бүсийн суманд ойн хортон маш их тархалттай</li> <li>• Малын бэлчээрлэлт ойн санг байгалийн аясаар тэлж ургах нөцлийг бууруулах аюултай</li> <li>• Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулахгүй бол ойн сан доройтох эрсдэл үүсэх</li> <li>• Унасан, хатсан модыг авч ашиглах ажлыг эрчимжүүлэхгүй бол түймрийн эрсдлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна</li> <li>• Одоо ашиглаж байгаа техник /хөрөө, сүх, машин/ хожуулыг авах боломжгүй учраас нутгийн иргэд ногоон мод унагах, бэлтгэх аюултай</li> <li>• ТХГН –ыг хамгаалахад хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор хамгаалалтын захиргаа, орон нутгийн захиргаа болон иргэдийн хооронд зөрчил гарах</li> </ul>

### ➤ **ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

- Орчны бүсийн ойн эко систем болон биологийн төрөл зүйлд нүүрлэж буй аюул, занал нь хүний буруу үйл ажиллагаа болон байгалийн хүчин зүйлийн нөлөөнөөс шалтгаалж байна.
- Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарим төрлийн саад бэрхшээл учирдаг. Үүнд, хууль бус ан агнуур, ойн түймэр, ойн хортон шавжийн тархалт, хууль бус мод бэлтгэл гэх мэт
- Дээрх зөрчлүүдээс шалтгаалан ой доройтол, хомсдол бий болж, ойн экологийн төлөв байдал өөрчлөгдөх, булаг шандын эх ширгэх, ургамлын нөмрөг сийрэгжих, зүйлийн бүрдэл хомсдох, ан амьтан дайжих, агнуурын нөөц илт багасах зэрэг аюул эрсдэл байна

- Мод бэлтгэл болон боловсруулах технологи хоцрогдсон байдал нь үхмэл мод, хожуулын их хэмжээний нөөцийг авч ашиглаж чадахгүй улмаар ногоон мод унагах сөрөг байдлыг бий болгож байна.
- Зэргэлдээ аймгийн сумууд ойн нөөц багатай учраас хууль бус мод бэлтгэл орчны бүсэд тодорхой хэмжээгээр байсаар байна.
- Орчны бүсийн ард иргэдийн гол хэрэгцээ түлшний мод бөгөөд дулааны алдагдал ихтэй зуух, пийшин ашиглаж эрчим хүчний хэмнэлт муутай гэр, байшинд амьдардаг хэв маяг өөрчлөгдөөгүй
- Ойн аж ахуйн арга хэмжээ хангалтгүй байгаагаас ойн байгалийн сэргэн ургалт шигүү болж модны таваарлаг чанар болон ойн экологийн үзүүлэлт буурах

#### ➤ **ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛ:**

- Доройтсон ойн үхмэл модны нөөцийг ашиглах технологи нэвтрүүлэх зайлашгүй шаардлагатай
- ОМБ-ын тоног, төхөөрөмжийг сайжруулах ялангуяа ойн аж ахуйн арга хэмжээ (арчилгааны огтлол хийх) явуулахад шаардлагатай машин механизар шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх
- Хожуул, унанги, үхмэл мод, мөчир гишүү боловсруулах ЖДҮ-ийг орон нутагт хөгжүүлэх
- Бүс нутгийн онцлогт тохирсон МҮГ-ыг хөгжүүлэх
- Ойн түймэр, хулгайн ан бусад зөрчлийн талаар түргэн шуурхай мэдээлэл хүргэхэд зайлашгүй шаардлагатай тоног төхөөрөмж байдаггүй. Тухайлбал, дуран, байр зүй тодорхойлох багаж, байгаль хамгаалагчидад бие хамгаалах хэрэгсэл гм зайлашгүй хэрэгцээтэй зүйлүүдээр хангахад дэмжлэг үлзүүлэх
- Тодорхой байршилүүдэд дрон, камержуулах зэрэг орчин үеийн технологиудийг нэвтрүүлж хяналтыг сайжруулахад төсөл хэрэгжүүлэх
- Орчны бүсэд амьдарч байгаа иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоомжид нийцсэн арга хэмжээг дэмжин хэрэгжүүлэх.

### 5.3.4 КЛАСТЕР-III БҮС НУТГИЙН ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ, МОД, МОДЛОГ НӨӨЦИЙГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүснэгт 49. Хэрэгжүүлэх төслийн санал

1. КЛАСТЕР –III БҮС НУТГИЙН ТХГН-Т ХЭРЭГЖҮҮЛЭХ ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭТЭЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ		
1.1. Ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолт явуулах машин, технологийн зүгшрүүлэлт, нутагшуулалтын туршилт, судалгааны төсөл		
Үе шат	Үр дүн	Ач холбогдол
<p>1.Ойд арчилгааны (сийрэгжүүлэх, завсрын, гэрэлжүүлэх, тохируулах) огтлолтын иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт судалгаа.</p> <p>2.Ойн цэвэрлэгээний иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт, судалгаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Шигүү ургасан зулзган, залуу ойд тохирсон арчилгаа, цэвэрлэгээний огтлолт явуулах технологийн схем (карт)-ийг боловсруулна.</li> <li>• Энэхүү технологийн схемд нийцүүлэн технологийн ажилбарыг гүйцэтгэх машин, багаж хэрэгслийн судалгаа явуулж, зүгшрүүлэлт, туршилт судалгаа явуулж, машин багаж хэрэгслийн сонголт хийнэ.</li> </ul>	<p>Экологийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шигүү ургаж буй модны ургах орчин сайжирч залуу ойн амьдрах чадвар дээшилнэ.</li> <li>- Ойн орчин эрүүлжиж, ойд хөнөөлт шавж, түймэр тархах эрчим буурна.</li> </ul> <p>Эдийн засгийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн ойн товаарлаг чанар дээшилнэ</li> <li>- Орчны бүсийн мод, модон материалын түүхий эдийн хангалт нэмэгдэнэ.</li> </ul> <p>Нийгмийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ойн аж ахуйн арга хэмжээ явуулах зорилго, зорилтууд тодорхой болно.</li> <li>- Ойн аричлгаа, цэвэрлэгээний огтлолтын сургалт, судалгаа явуулах бодит орчин бүрдэнэ.</li> </ul>
1.2. Ойн өндөр хожуул огтлолтын машин, технологийн зүгшрүүлэлт, нутагшуулалтын туршилт, судалгааны төсөл		
<p>Өндөр хожуул огтлолтын иж бүрэн машин, технологийг зүгшрүүлэх, нутагшуулах туршилт судалгаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Өндөр хожуулын огтлолт явуулах технологийн схем (карт)-ийг боловсруулна.</li> <li>• Энэхүү технологийн схемд нийцүүлэн технологийн ажилбарыг гүйцэтгэх машин, багаж хэрэгслийн судалгаа явуулж, зүгшрүүлэлт, туршилт судалгаа явуулж, машин багаж хэрэгслийн сонголт хийнэ.</li> </ul>	<p>Экологийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өндөр хожуулыг авснаар модны ургах орчин сайжирч залуу ойн амьдрах чадвар дээшилнэ.</li> <li>- Ойн орчин эрүүлжинэ</li> </ul> <p>Эдийн засгийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орчны бүсийн иргэдийн түлшний модны хэрэгцээний хангалт нэмэгдэнэ.</li> </ul> <p>Нийгмийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ОМБ-ын техник технологи сайжирна</li> </ul>
1.3. Доройтсон ойн байгалийн үхмэл модыг боловсруулах технологийн горим тогтоох туршилт, судалгааны төсөл		

<p>Байгалийн үхмэл модны доройтлын зэрэглэлээс хамаарч дулаан, гидролиз, пиролиз, механик аргаар боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн горимыг боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсруулалтын технологийн горимд зохицсон багаж, тоноглолын тоног төхөөрөмж сонгогдоно.</li> <li>• Үхмэл модныг боловсруулан үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхойлоно</li> </ul>	<p>Экологийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ойн сангийн чанар чансааг сайжруулах, ойг эрүүлжүүлэх, ойн түймэр, хортон шавьжинд идэгдэх хор хөнөөлийг багасгах</li> <li>- Ойн орчин эрүүлжинэ</li> </ul> <p>Эдийн засгийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Доройтолд орсон ойн үхмэл модыг үйлдвэрлэл эдийн засгийн эргэлтэнд оруулах, боломж бүрдэнэ.</li> </ul> <p>Нийгмийн ач холбогдол нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байр шинээр нэмэгдэх</li> <li>- Ой бүхий орон нутагт ойн нөхөрлөлүүд, ойн мэргэжлийн байгууллагуудын чадамж сайжирна</li> </ul>
<p><b>1.4. Бүс нутгийн онцлогт тохируулж мод үржүүлгийн газар байгуулах төсөл</b></p>		
<p>Бортогонд тарьц,суулгац ургуулах механикжсан технологийг нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Шилмүүст модны тарьцыг уламжлалт технологийн дагуу хүлэмжинд үрээр тариалж нэг настай тарьц ургуулж</li> <li>• Хоёр болон түүнээс дээш настай тарьцыг бортогонд шилжүүлэн суулгаж, ургуулах ажлыг механикжуулах технологийн судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийгдэнэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тарьцыг бортогонд шилжүүлэн суулгах технологи хөгжүүлснээр ойжуулалтын ажлын улирлын хамаарлыг багасна</li> <li>- Суулгацын амьдралтын хувь дээшилнэ</li> <li>- Нэгж талбайгаас ургуулж авах тарьцны тоо олон болно</li> <li>- Шилмүүст модны үрийг бортогонд тарьж ургуулах болон тарьцыг бортогонд шилжүүлэн суулгах технологи хөгжүүлснээр мод үржүүлгийн ажилчдын ажлын байрны нөхцөл эрс сайжирна</li> </ul>
<p><b>1.5. Ойн дагалт баялаг боловсруулах цехийн төсөл</b></p>		
<p>Ойн дагалт баялаг боловсруулах бага оворын хүчин чадалтай үйлдвэрлэл</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Самарын идээ боловсруулах цехийн төсөл</li> <li>• Жимсний өтгөрүүлсэн жүүс, чанамал боловсруулах цехийн төсөл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Орчны бүсийн иргэдийн орлого нэмэгдэнэ</li> <li>- Ажлын байр нэмэгдэнэ</li> <li>- Дагалт баялагын нөөцөө зүй зохистой ашиглах туршлагатай болно</li> </ul>
<p><b>2. КЛАСТЕР –II БҮС НУТГИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b></p>		
<p><b>2.1. ОМБ-ыг орчин үеийн машин механизар шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх төсөл</b></p>		
<p>Арчилгаа, цэвэрлэгээний</p>	<p>Олон талт санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойн экологийн төлөв байдла сайжирна</li> </ul>

огтлолт явуулах машин механизмч технолгийн шинэчлэл хийх	хөнгөлөлтэй нөхцлөөр авах боломжийг бий болгох	- ОМБ-ын чадамж сайжирна
<b>2.2. Сургалт, сурталчилгааны ажлыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах төсөл</b>		
1. Ойн анги, ОМБ болон ойн нөхрөлүүдэд зориулсан чадавхжуулах сургалт 2. Орчны бүсийн иргэд, малчидад зориулсан мэдлэг, мэдээлэл өгөх сургалт 3. Хүүхэд, залуучуудад зориулсан экологийн боловсрол олгох сургалт	1-р сургалтын хүрээнд <ul style="list-style-type: none"> <li>• мэргэжил аргагүйн сургалт</li> <li>• шинэ техник технологи, инновацийн туршлага судлуулах</li> </ul> 2, 3-р сургалтын хүрээнд <ul style="list-style-type: none"> <li>• газарзүйн мэдээллийн сангийн талаар</li> <li>• ТХГН-ийн тухай хууль, журам</li> <li>• Биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдол</li> <li>• Уур амьсгалын өөрчлөлтийн талаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойн анги, ОМБ-ын хүний нөөцийн чадавхи сайжирна</li> <li>- Ойн нөхөрлөлүүд ойн нөөцийг хамгаалах менежментийг зөв зохион байгуулна</li> <li>- Модыг оновчтой ашиглах талаар орчны бүсэд амьдарч буй иргэдийн мэдлэг, ухамсар дээшилнэ.</li> <li>- ТХГН-ын хамгаалалтын захиргаа иргэд хооронд гардаг зөрчил багасна.</li> <li>- Байгаль хамгаалах ажилд оролцох оролцоо нэмэгдэнэ</li> <li>- Залуу үе байгаль орчинтой зөв харьцах</li> <li>- Байгаль орчны чиглэлээр мэргэжил сонгох сонирхол нэмэгдэнэ</li> </ul>
<b>2.3. Хууль бус мод бэлтгэл, хулгайн антай тэмцэх, хяналтыг сайжруулах төсөл</b>		
Орчин үеийн технологиудийг нэвтрүүлэх	Тодорхой байршилүүдийг камержуулах, дроноор хяналт тавих зэрэг орчин үеийн технологиудийг нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль бус мод бэлтгэл, хулгайн ан хийх буурна</li> <li>- Байгаль хамгаалагч нарын аюулгүй ажиллах орчин сайжирна</li> </ul>
<b>3. КЛАСТЕР –III БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ</b>		
<b>3.1. Бөөрөнхий модноос авах зүсмэлийн гарцыг нэмэгдүүлэх технологи хөгжүүлэлтийн төсөл</b>		
1 Зүсмэл үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэлийн эзэлхүүний болон чанарын гарцын бодит хэмжээсүүдийг тодорхойлно	<ul style="list-style-type: none"> <li>• Бага, дунд хүчин чадлын зүсмэрийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологийн горимын сонголт хийх.</li> <li>• Хамгийн өндөр гарцтай зүсэлт явуулах зүсэлтийн тооцоо гаргаж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Технологийн шинэчлэлт хийж модон зүсмэл материалын эзэлхүүний болон чанарын гарцыг нэмэгдүүлснээр зүсмэлийн үйлдвэрлэлээс гарах үлдэцийг багасна.</li> <li>- Зүсмэл материалын чанарын зэргийн гарцыг тодорхой хувиар нэмэгдүүлсэнээр үйлдвэрлэлийн ашиг нэмэгдэх боломжтой.</li> </ul>

<p>2.Зүсмэл үйлдвэрлэлийн шинэ технологи бүхий үйлдвэрлэл явуулж болох туршилтыг хийх.</p>	<p>туршилтын зүсэлтийг явуулан технологи, тоног төхөөрөмжийн сонголтыг хийнэ.</p>	<p>- Сортиментийн эзэлхүүний гарцыг 15-20 хувь, чанарын гарцыг зэрэг тус бүрээр 5-аас багагүй хувиар дээшлүүлнэ.</p>
<p>3.2. Модлог био түлш үйлдвэрлэх технологийн төсөл</p>		
<p>Доройтсон ойн үхмэл мод болон зүсмэлийн үйлдвэрийн үлдэц модоор шахмал биотүлш үйлдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>Модлог био түлш үйлдвэрлэх технологийг боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх</li> </ul>	<p>Доройтсон ойн үхмэл модны нөөцийг үйлдвэрлэл-эдийн засгийн эргэлтэд оруулан биотүлш үйлдвэрлэн Клатер- III бүс нутгийн болон баруун бүсийн ойн нөөц багатай сумуудын түлшний хэрэгцээнд хэрэглэж хэвшүүлэх өндөр ач холбогдолтой</p>



## 5.4. КЛАСТЕР- IV БҮС НУТГИЙН ТХГН-ИЙН ОРЧНЫ БҮСИЙН СУМУУДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 5.4.1. ХОВД АЙМГИЙН МЯНГАД, ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Мянгад сум:** Ховд аймгийн зүүн хойд хэсэгт Улаанбаатар хотоос 1545 км, Аймгийн төвөөс 45 км зайд байрладаг. Хойд талаараа Увс аймгийн Өмнөговь, Өлгий сум, Баруун талаараа Ховд аймгийн Буянт, Ховд, Эрдэнэбүрэн, зүүн талаараа Дөргөн сумдтай хиллэдэг. Далайн төвшнээс дээш дундажаар 1200-1800 метр өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Алтайн уулсын салбар, их нууруудын хотгорт харъяалагдана. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой. Мянгад сум нь 325850 га нутаг дэвсгэртэй, засаг захиргааны 5 багтай, 923 өрх, 3704 хүн амтай, 239044 толгой малтай. Мал сүргийн тоогоороо аймагтаа 4 дүгээр жагссан байна. Дэд бүтэц сайн хөгжсөн. Аймаг, сум хооронд хатуу хучилттай замаар холбогдсон, баг хооронд ердийн шороон замтай ба Ховд голд цементэн болон модон гүүрүүдтэй. Сумын төвд 2019 онд төвлөрсөн дулааны станцыг байгуулан албан байгууллагын 11 объект, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 5 объект, айл өрхийн 5 байшинг дулааны шугам сүлжээнд холбосон байна.

**Эрдэнэбүрэн сум:** Ховд аймгийн баруун хойд хэсэгт Улаанбаатар хотоос 1461 км Аймгийн төвөөс 61 км зайд байрладаг. Тус сум нь хойд талаараа Баян-өлгий аймгийн Толбо, Алтанцөгц, Баяннуур сумтай, зүүн талаараа Ховд голоор Ховд аймгийн Мянгад сумтай, Урд талаараа Буянт сумтай Баруун талаараа Ховд сумтай тус тус хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1182-4208 метрт өргөгдсөн, өндөр уулс, говь тал хосолсон нутагтай. ус сумын нутаг дэвсгэр дээгүүр Ховд аймгаас Баян-Өлгий аймаг, ОХУ- тай харилцах улсын чанартай 65 км авто зам дайран өнгөрдөг. Тус суманд 1987 онд тэжээлийн аж ахуй байгуулагдан 2000 га талбайд үр тариа, тэжээлийн ургамал, төмс хүнсний ногоо тариалж байсан уламжлалтай. Цаашид тэжээлийн аж ахуйн 2000 га талбайг усжуулж суваг шуудууг сэргээн засварлаж байгаа.

Хүснэгт 51. Сумдын хүн ам болон малын тоо

Аймгийн нэр	Сумын нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо	Малын тоо \төрлөөр\				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Ховд	Мянгад	913	3654	1393	11956	14409	82362	117575
	Эрдэнэбүрэн	662	2407	1297	8794	5505	64632	76629

## 5.4.2. ОЙН НӨӨЦ, ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА


Кластер–IV бүс нутгийн Цамбагарав уулын БЦГ-ын орчны бүсийн Ховд аймгийн Мянгад, Эрдэнбүрэн сумуудын ойн нөөц, ойн дагалт баялаг ашиглалтын талаар дүн шинжилгээ хийхийн тулд ойн төлөв байдал, ойн менежментэд тулгарч буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, ойн менежментийн ороцогч талуудын саналыг оролцооны аргаар тодорхойлж авсан.



Зураг 47. Ховд аймгийн Мянгад, Эрдэнбүрэн сумын оролцогч талуудтай хийсэн уулзалт

Хүснэгт 52. Кластер-IV: ойн аж ахуйн арга хэмжээ

№	Аж ахуйн арга хэмжээ, га	Кластер-IV
1	Арчилгааны огтлолт	-
2	Цэвэрлэгээний огтлолт	-
3	Ойжуулалт	-
4	БСУ туслах	-
5	Самар түүх	-
6	Жимс түүх	-
7	Өндөр хожуулыг тайрах	-



Зураг 48. Оролцоогы аргаар зураглуулсан зураг

Кластер–IV Цамбагарав уулын БЦГ-т харьяалагдах Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн сумдын нутгаас ТХГ-ын хилд орсон хэсэгт одоогийн байдлаар ой байхгүй гэсэн судалганы үр дүн гарсан.



Зураг 49. Ойн бус материалаар барьсан хашаа



Зураг 50. Бургасаар хийсэн гэрийн мод



Зураг 51. Гадны аймаг, сумдаас худалдаж авдаг модон хавтангаар хийсэн тавилга

Хүснэгт 53. Ойгоос олж байгаа орлого

<b>Ховд аймгийн Мянгад сум</b>	
Сумын ойн анги	
ОМБ	
Нөхөрлөл	
	Эзэмшлийн талбай, га -
Сумын татварын нийт орлого /төг/:	
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	
Байгалын ургамлын нөөц ашигласны	
Ойн нөөц ашигласны төлбөр	
Модны хэрэгцээ	

Түлшний модны хэрэгцээ	өрх (2 - 3 м <sup>3</sup> )	
Хэрэгцээний мод	-	
Мужааны жижиг цех	-	
<b>Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум</b>		
Сумын ойн анги	Байхгүй (Ховд аймгийн ойн анги)	
ОМБ	-	
Нөхөрлөл	1 (идэвхтэн байгаль хамгаалагч )	8 хүн
	Эзэмшлийн талбай, га – 1 багт 2 га хариуцуулдаг	
Сумын татварын нийт орлого /төг/:		
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	- 33.798.740 (2021)	
Байгалын ургамлын нөөц ашигласны	1.556.000 (2020 он ) 1.494.000 (2021 он)	
Ойн нөөц ашигласны төлбөр	-	
<b>Модны хэрэгцээ</b>		
Түлшний модны хэрэгцээ	200 өрх (2 - 3 м <sup>3</sup> )	600 м <sup>3</sup>
Хэрэглээний мод	Завхан аймгаас авдаг – 60-80 м <sup>3</sup> (Дамжин өнгөрүүлэх гарал үүслийн гэрчилгэтэй) - Банз, Палк, Зах банз г.м	
Мужааны жижиг цех		

#### 5.4.3. SWOT ДҮН ШИНЖИЛГЭЭ

Кластер- IV бүс нутгийн Цамбагарв уулын БЦГ –ын орчны бүсд хамрагдах сумдын ойн нөөц болон дагалт баялаг ашиглалтын төлөв байдлад SWOT шинжилгээг хийхдээ тус сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумын 2015-2025 оны хөгжлийн төлөвлөгөө болон орон нутгийн оролцогч талуудаас гаргасан саналыг тусгасан хувилбараар үзүүлэв.

Хүснэгт 54. SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Хүн ам нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх уламжлалт арга туршлагатай</li> <li>• Ойн нөөцөөс хамаарал багатай амьдардаг</li> <li>• Бургасаар гэрийн мод хийх уламжлалтай</li> <li>• Хамгаалатын зурвас байгуулж эхэлсэн</li> <li>• Аялал жуулчлал хөгжүүлэх, байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, язгуур урлагын өв уламжлалтай.</li> <li>• Усан цахилгаан станц баригдах болсон</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ойн нөөц бага</li> <li>• Ойн нөхөрлөлийн тоо хангалтгүй</li> <li>• Бэлчээрийн ургамлын тархалт сийрэг, гарц, ургац бага, бэлчээрийн даац хэтэрсэн,</li> <li>• ойн сангийн тодорхой хэсгийн мал бэлчээрлэлтэнд өвлийн улиралд ашиглаж байна.</li> <li>• Ойг зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах, үр түүх, тарьц, суулгац ургуулах ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн боловсон хүчин байхгүй</li> <li>• Тарьц суулгац гаднаас авдаг</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Модон материалын хэрэгцээ гадны аймаг сумаас авдаг</li> <li>• Ойг нөхөн сэргээх, ойн дагалт баялагийн ашиглах чиглэлээр үйлдвэрлэл хөгжөөгүй.</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Эрсдэл, аюул</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Байгалийн бүс бүслүүр, ландшафтын хэвшинжийн олон янз байдалд нийцсэн тогтвортой ногоон хөгжлийн хандлагыг төлөвшүүлэх, байгаль хамгаалах уламжлалыг сэргээн хөгжүүлэх боломжтой.</li> <li>• МҮГ байгуулан ойн нөөцийг нэмэгдүүлэх боломжтой</li> <li>• Модон түүхий эдээ гаднаас авдаад гэр ахуйн хэрэгцээний модон тавилга үйлдвэрлэдэг цех байгуулах</li> <li>• Байгалийн үзэсгэлэнт газар, дэлхийд данстай нэн ховор, ховордсон ан амьтан, ургамлын нөөцийн зүй зохистой менежментийг нэвтрүүлэх, аялал жуулчлал зэрэг аж ахуйн салбарыг хөгжүүлэх боломжтой.</li> <li>• Хүнсний нарийн ногооны аж ахуй, хүлэмжийн аж ахуй эрхлэх, түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх туршлага дээр тулгуурлан ойг зориудаар тарьж ургуулах чиглэлийн үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой.</li> <li>• Ойн зурвас байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, булаг шандын эхийг хамгаалах, мод тарих, иргэдийг хашаандаа, өвөлжөө, хаваржаандаа мод тарихад уриалах зэрэг амьдрах орчноо сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой</li> <li>• Нартай өдрийн тоо их, вегатацын хугацаа урт тул ургамал тарихад давуу</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Уур амьсгалын дулаарал, хүчтэй салхи, шороон шуурга, үер, ган зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ихэсэж байгаа ба цаашид ч улам нэмэгдэж болзошгүй эрсдэлтэй</li> <li>• Цагаан бургас авахыг хориголсоноос гэрийн мод үйлдвэрлэдэг уламжлал алга болох</li> <li>• Биологи, экологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутгийн хамгаалалт, хяналтыг дээшлүүлэхгүй бол үнэ цэнэтэй, нэн ховор, ховор амьтан ургамал устах эрсдэлтэй</li> <li>• Бэлчээр ашиглах, хамгаалах гэрээ байгуулах, даац хэтрэлтийг зохицуулах норм, эдийн засгийн механизм нэвтрүүлж, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулахгүй бол ойн сан доройтох эрсдэл үүсээд байна.</li> <li>• Байгаль хамгааллын арга хэмжээг иргэд нөхөрлөлд түшиглэсэн иргэдийн зүй ёсны эрхийг баталгаажуулах замаар эзэнтэй болгохгүйгээр дан ганц төрийн байгууллагын хяналтын хүчин чадал буурсаар байгалийн нөөц доройтох эрсдэлтэй</li> <li>• Усны эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийг тогтоож төлөвлөхгүй бол усны нөөц хомсдох, бохирдох эрсдэлтэй</li> </ul>

### ➤ **ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

- Энэ тариалангийн бүс нутагт салхи, элсний нүүдэл ихэсэж байгаа
- Цагаан бургасны нөөц багасаж байгаа
- МҮГ байгуулах
- 2020 онд Цамбагарав уулын 3 дахь нуур сэтэрч үер болож байгалийн гамшигт үзэгдэл болсон. Баянгол баг Хад үзүүрийн гүүр хавийн мод бут сөөг бүгд устсан

- Алслагдмал суманд жимс жимсгэнэ тариалж байгаа нэмүү өртөг шингээн үйлдвэрлэж бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг байдаггүй
- Цагаан бургасыг нь авахыг хориглосноос болоод гэр хийдэг уламжлал тасрах гээд байна. Хулгайгаар бэлдэж цөөн тооны гэр хийж байна.
- Модны хэрэгцээ 100 хувь өөр аймгуудаас авдаг. Сумын төвийн айлууд хашаагаа банзан хашаагаар солих, барилгын дээвэр, хийхэд зүсмэл банз худалдан авдаг.
- Ойн нөхөрлөл, мэрэгжлийн байгууллага гэж байдаггүй.
- Одоо л жимс жимсгэний аж ахуй эрхлэж эхлээд байна. Дэмжлэг хэрэгтэй байна.
- Гэр ахуйн тавилга хийхдэг жижиг цех байдаггүй учраас модон хавтангаар хийсэн эцсийн бүтээгдэхүүн гадны аймгуудаас худалдаж авдаг
- Элсний нүүдэл, цөлжилт эхсээд байгаа байгаа газрыг хамгаалж чаддаггүй
- Ховд голын голдролыг өөрчилсөнөөс болоод гүрээ нь урсахаа больсон Тохойтын аралын бургас, улиас бүгд хатсан.
- Байгаль орчны чиглэлээр орон нутгийн хүүхдүүд мэргэжил сонгохгүй байна.
- Мод ургуулах, арчлах, ойн арга хэмжээ авах талаар сургалт, семинар хангалтгүй

#### ➤ **ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛ:**

- Элсний нүүдэл, цөлжилт их явагдаж байгаа газрыг хамгаалах ойжууллалтын бүс байгуулах
- МҮГ байгуулах
- Мод ургуулах, арчлах, ойн арга хэмжээ авах талаар сургалт, семинар авч одоо ажиллаж байгаа хүмүүсийнхээ мэдлэг, чадварыг дээшлүүлэх
- Ховд голын голдролыг өөрчилсөнөөс болоод гүрээ нь урсахаа больсон Тохойтын аралыг нөхөн сэргээх шаардлагатай байна.
- Сумын сургуулийн ахлах ангийн хүүхдүүдээс байгаль орчны чиглэлээр суралцах сонирхолтой сургагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх
- Одоо л жимс жимсгэний аж ахуй эрхлэж эхлээд байна. Дэмжлэг хэрэгтэй байна.
- Сумын модон бүтээгдэхүүний хэрэгцээг хангах мод боловсруулах жижиг цех байгуулах хэрэгцээ шаардлага байна.

#### 5.4.4. КЛАСТЕР-IV БҮС НУТГИЙН ТХГН-ИЙН ОЙН ДАГАЛТ БАЯЛАГ, МОД, МОДЛОГ НӨӨЦИЙГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүснэгт 55. Хэрэгжүүлэх төлсийн санал

1. КЛАСТЕР –II БҮС НУТГИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРГАСАН САНАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ		
1.1. Сургалт, сурталчилгааны ажлыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах төсөл		
<p>1.Ойн анги, ОМБ болон ойн нөхрөлүүдэд зориулсан чадавхжуулах сургалт</p> <p>2.Орчны бүсийн иргэд, малчидад зориулсан мэдлэг, мэдээлэл өгөх сургалт</p> <p>2.Хүүхэд, залуучуудад зориулсан экологийн боловсрол олгох сургалт</p>	<p>1-р сургалтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• мэргэжил аргазүйн сургалт</li> <li>• шинэ техник технологи, инновацийн туршлага судлуулах</li> </ul> <p>2, 3-р сургалтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• газарзүйн мэдээллийн сангийн талаар</li> <li>• ТХГН-ийн тухай хууль, журам</li> <li>• Биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдол</li> <li>• Уур амьсгалын өөрчлөлтийн талаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойн анги, ОМБ-ын хүний нөөцийн чадавхи сайжирна</li> <li>- Ойн нөхөрлөлүүд ойн нөөцийг хамгаалах менежменийг зөв зохион байгуулна</li> <li>- Модыг оновчтой ашиглах талаар орчны бүсэд амьдарч буй иргэдийн мэдлэг, ухамсар дээшилнэ.</li> <li>- ТХГН-ын хамгаалалтын захиргаа иргэд хооронд гардаг зөрчил багасна.</li> <li>- Байгаль хамгаалах ажилд оролцох оролцоо нэмэгдэнэ</li> <li>- Залуу үе байгаль орчинтой зөв харьцах</li> <li>- Байгаль орчны чиглэлээр мэргэжил сонгох сонирхол нэмэгдэнэ</li> </ul>
1.2. Мод үржүүлгийн газар байгуулах төсөл		
2. КЛАСТЕР –IV БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ		
2.1. Гэр ахуйн модон эдлэл үйлдвэрлэх цехийн төсөл		

## 6. ДҮГНЭЛТ



## 7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## Хавсралт 1: Судалгааны аргазүй

**Зорилт-1.** Кластер бүс нутгийн ойн сангийн суурь үзүүлэлтийг тодорхойлох арга зүй:

- 1.1. Кластер бүс нутгийн ойн сангийн суурь үзүүлэлтийг ойн мэргэжлийн байгууллага тухайн бүс нутагт хамгийн сүүлд хийсэн ой зохион байгуулалтын тайланд анализ-сентизийн аргаар задлан шинжилгээ хийх аргачлалаар гүйцэтгэнэ. Үүнд:
  - Увс аймгийн ойн санд “Гранд форест” ХХК-ны 2020 онд хийсэн Ой зохион байгуулалтын ажлын тайлан
  - Ховд аймгийн ойн санд “Мөнх ногоон жодоо”ХХК, “Хатан форест”ХХК, “Залуу төгөл”ХХК-ны 2020 онд хийсэн Ой зохион байгуулалтын ажлын тайлан
  - Баян-Өлгий аймгийн ойн санд “Мөнх ногоон жодоо”ХХК-ны 2017 онд хийсэн Ой зохион байгуулалтын ажлын тайлан
- 1.2. Судалгаанд хамрагдах 4 кластер газар нутгийн хэмжээнд ТХГН-ын менежментийн төлөвлөгөө болон өмнө нь хийгдсэн судалгааны тайлан мэдээ, цуглуулна (Хүснэгт 2).
  - Цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж нэмэлт судалгаа хийх ажлын хэмжээг тодорхойлно.
  - Кластер тус бүрээр 1:100,000-аас багагүй масштабын ойн бүхэвчийн ажлын зургууд үйлдэнэ. /Байр зүйн болон сансрын зураг/ Үүнд: Кластер тус бүрээр ойн одоогийн байдлыг харуулсан ойн төлөв байдлын зургийг боловсруулна.
- 1.3. Кластер бүс нутаг тус бүрийн ойн сангийн дэлгэрэнгүй мэдээллийн сан бүрдүүлнэ (Хүснэгт 3).

Кластер тус бүрийн ойн таксацын дундаж үзүүлэлтүүдийг ялгарлын түвшинд тодорхойлно. Үүнд:

  - Ойн талбай
  - Ойн нөөц
  - Модны төрөл зүйл
  - Модны өсөлт
  - Модны насжилт,
  - Модны өндөр,
  - Диаметр зэрэг,

Кластер бүс нутаг тус бүрийн ойн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлно. Үүнд:

  - Байгалийн сэргэн ургалтын байдал
  - Ойн хомсдлын төлөв байдал
  - Ойн доройтлын төлөв байдал

- Ойн түймэр, хөнөөлт шавжид өртсөн байдал,
- Ой модны ашиглалт, мод бэлтгэлийн байдал
- Ойн аж ахуйн арга хэмжээ
- Ойд хийгдэж байгаа арчилгаа, цэвэрлэгээ

Ой зохион байгуулалтын судалгаагаар тогтоосон хэсэглэл, ялгарлын түвшний мэдээллийг ашиглан ойн сангийн талбайг төрлөөр нь байгалийн ой, сөөг, торлог, шатсан, мод бэлтгэсэн, ойн хөнөөлт шавж өвчинд нэрвэгдсэн, тармаг ой болон ойн сан дахь ойгүй талбай гэж ангилан ойн тархалт, төлөв байдлын зураг боловсруулна. Ой зохион байгуулалтаар ойн ялгарал тус бүрт тодорхойлсон таксацын үзүүлэлтийг ашиглан модны төрөл тус бүрээр нь ойн насны бүлгийн ангиар ялгаж ойн тархалтын зургаар харуулна.

1.4. Орон нутагт оролцооны аргаар зураглал боловсруулах:

- Ойн төлөв байдлыг тодруулах зураг /1:100,000-аас багагүй масштабтай сансрын зураг/
- Ойн арга хэмжээг төлөвлөх зураг /дээрхтэй адил зураг/
- Түймэр, ойн хөнөөлт шавжийн байршил, авсан арга хэмжээ, тэмцэл явуулсан он зэргийг зураглах /дээрхтэй адил зураг/
- Өвөлжөө, хаваржаа болон бусад суурин газар болон газар орны нэршил тодруулах зураг /1:100,000-аас багагүй масштабтай байр зүйн зураг/
- Ойд өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрийг эрэмбэлэх зураг /1:100,000-аас багагүй масштабтай сансрын зураг/
- Дагалт баялгийн байршлыг тодруулах зураг /1:100,000-аас багагүй масштабтай сансрын зураг/
- Голын дагуух бургас
- Татмын ой

1.5. Кластерт хамрах аймаг, сумын ой зохион байгуулалтын материал ашиглах бөгөөд орхигдсон болон өөрчлөлт орсон газар нутагт тодруулалт хийж хэмжилт тооллогоор нэмэлт мэдээлэл цуглуулна. Сумын ой зохион байгуулалтад ороогүй жижиг төгөл ой, татмын ой, голын дагуух бургасан шугуй зэрэг содон хэсэг, өөрчлөлт орсон хэсэг, эрсдэлд өртөмтгий хэсэгт нэмэлт тодруулга хэмжилт хийнэ. Нэмэлт тодруулгыг дараах арга зүйгээр хийнэ. Үүнд:

**Хээрийн хэмжилтийн түр аргачлал:** Энэ түр аргачлал нь сонгогдсон газар нутгийн ойн мэдээг шинэчлэх зорилгоор гол хэмжилтүүдийг цуглуулахад ашиглагдана. Нөхцөл байдалд тохируулан хэмжилтийг богино хугацаанд оновчтой авч, байгаа байдлыг тодруулахад чиглэсэн, нөгөө талаар өөр газар нутгийн бусад судалгаанд ашиглах аргачлал биш тул шинжлэх ухааны болон эрх бүхий байгууллагаар

хэлэлцүүлж батлуулах шаардлагагүй. Хэмжилтийг багц дээж талбайн аргад суурилан хийнэ.

**Багц дээж талбайн цэгийн байршил тоо:** Кластер тус бүрт өмнө нь хийгдсэн “ойн тархалтын зураг”-г өндөр нарийвчлалтай сансрын зурагт ялгарлаар нь бүлэглэж /цаашид бүлэг ялгарал/ хуваан зураг дээр тод ялгарах содон хэсэг бүрт хэмжилтийн цэгийг сонгон байрлуулна. Дээж талбай хооронд 250 метрийн зайтай байна. Дээж талбайн тоог талбайн хэмжээнээс харьцангуйгаар хамааруулж тогтооно. Гэхдээ талбайн хэмжээнээс үл хамааран дээж талбайн тоо 10-аас хэтрэхгүй. Мөн багадаа нэг байна.  $1 \leq N \leq 10$

**Багц дээж талбайн байршил:** Дээж талбай нь 4 хэмжилтийн цэгээс бүрдэнэ. Хэмжилтийг жишүүр (призм) багажаар хийнэ. Төв цэг буюу 1-р цэгээс бусад 3 цэг нь ижил 20 метрийн зайд байна. Төв цэгээс 2-р цэг  $0^\circ$ , 3-р цэг  $120^\circ$ , 4-р цэг  $240^\circ$ -д тус тус байрлана. 1-р цэгт GPS багажаар очиж бусад цэг болох 2, 3, 4-р цэгүүдэд буссоль багажаар дараалан хүрч хэмжилтийг хийж дуусгана. Хоорондын зайг хос алхамаар хэмжинэ.

**Дээж талбайд хийгдэх ажил:** Төв цэг дээр 6 метрийн радиус бүхий тойрогт бүдүүн нь 6 см-ээс дээш бүх хатсан, унанги, хожуул зэргийг тоолно. Хатсан модны өндрийг өндөр хэмжигчээр, диаметрийг хэмжих ацаар цээжний өндөрт хэмжих бол унангийн уртыг метрээр, голын диаметрийг ацаар хэмжинэ. Унангийн зөвхөн тойрог дахь хэсгийг тооллогот авна. Хожуулын диаметрийг өндрийн хагаст хэмжих бөгөөд өндрийг метрээр хэмжинэ. Хатсан, унанги, хожуулын өмхөрлийг 1-3 зэргээр зэрэглэх буюу 20-90 хүртэл хувийн өмхөрлийг илэрхийлнэ. Хатсан, унанги, хожуулыг нэг ижил хүснэгтэнд бичих бөгөөд хатсан-Х, унанги-У, хожуул-Хо гэж тэмдэглэнэ (Хүснэгт 4). Хэмжилтийг хойд зүгээс эхлэн нар зөв эргэх замаар гүйцэтгэнэ. Сөөгийг сийрэг, дунд, нягт гэсэн 3 ангиллаар үнэлж бүртгэнэ. Эдгээр ажил зөвхөн төв цэг дээр хийгдэх бөгөөд бусад 3 цэг дээр хийгдэхгүй.

**Бүх цэг дээр хийх ажил:** Ургаа модыг төрлөөр болон насны бүлгээр ялгаж жишүүр багажаар тоолно. Тоолохдоо хойд зүгээс эхлэн нар зөв эргэж гүйцэтгэнэ. Төрөл тус бүрээс болон насны бүлэг бүрээс дундаж нэг модны өндөр диаметрийг хэмжинэ.

**Цэгт хүрэх:** Дээж талбай буюу төв цэгийн байршлыг GPS багажаар солиболцлыг тодорхойлж хэмжилтийг гүйцэтгэнэ. Буссоль багажаар  $0^\circ$ -т харан 20 метр явж 2-р цэг. Эндээс  $150^\circ$ -аар 35 метр яваад 3-р цэгт хүрнэ. 3-р цэгээс 4-р цэгт  $270^\circ$ -аар 35 метр явж хүрнэ (Зураг 2, 3).

**Хэрэглэх багажууд:** GPS, буссоль, жишүүр, тоологч, хэмжих ац, vertex, рек, бүртгэлийн маягт, самбар, харандаа, баллуур, шүхэр зэрэг болно. Хээрийн судалгаанд ашиглагдах багажнуудыг Зураг 4-т үзүүлэв.

**Кластерт хамрагдсан нутаг дэвсгэрийн ойн судлагдсан байдал,  
судалгаанд ашиглах мэдээний жагсаалт**

Хүснэгт 2

№	Мэдээний Нэр	Хамрах аймгийн нэр	Сум/газрын нэр	Он	Мэдээний формат
1	Ой зохион байгуулалтын мэдээ /таксацын бичлэг/	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан	2020	*dbf
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн	2020	
		Баян-Өлгий	8. Булган	2017	
2	Ойн зургийн мэдээ /хэсэглэл, ялгарлаар/	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан	2020	*shp
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн	2020	
		Баян-Өлгий	8. Булган	2017	
3	Ой зохион байгуулалтын тайлан	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан	2020	*doc *pdf
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн	2020	
		Баян-Өлгий	8. Булган	2017	
4	Олон зорилтот үндэсний ойн тооллогын цэгийн солбицол болон цэг тус бүрийн бүртгэлийн мэдээ	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан	2014	*shp *pdf
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн		
		Баян-Өлгий	8. Булган		
5	Ой зохион байгуулалтын хээрийн хэмжилт тооллого хийсэн цэгийн	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан	2020	*shp *pdf *jpeg
		Ховд	5. Булган	2020	

	солбицол болон бүртгэлийн мэдээ		6. Мянгад 7. Эрдэнэбүрэн		
		Баян-Өлгий	8. Булган	2017	
6	Байр зүйн зураг	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан		*jpeg *tiff
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн		
		Баян-Өлгий	8. Булган		
7	ТХГН-ын хилийн цэс болон бусад мэдээлэл	Увс	1. Түргэн уулын ДЦГ 2. Хан Хөхийн нуруу		*shp, *pdf
		Ховд	3. Булган гол, Их Онгогийн БЦГ 4. Цамбагарав уулын БЦГ		
		Баян-Өлгий	5. Мөнххайрхан уулын БЦГ		
8	Хиймэл дагуулын мэдээ - Landsat - Sentinel	Увс	1. Түргэн уулын ДЦГ 2. Хан Хөхийн нурууны БЦГ	2018 2020	*geotiff *img
		Ховд	3. Булган гол, Их Онгогийн БЦГ 4. Цамбагарав уулын БЦГ		
		Баян-Өлгий	5. Мөнххайрхан уулын БЦГ		
9	Орон зайн мэдээлэлүүд /засаг захиргааны зураг, ургамал, хөрс, байгалийн бүс бүслүүр, замын сүлжээ, гол, ус нуур, цэвдэг, газар ашиглалт зэрэг мэдээний давхаргууд/	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан		*shp
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн		
		Баян-Өлгий	8. Булган		
10	Сумын ойн менежментийн төлөвлөгөө	Увс	1. Түргэн 2. Өндөрхангай 3. Зүүнхангай 4. Цагаанхайрхан		*doc *pdf
		Ховд	5. Булган 6. Мянгад 7. Эрдэнэбүрэн		

		Баян-Өлгий	8. Булган		
11	ТХГ-ын менежментийн төлөвлөгөө	Увс	1. Түргэн уулын ДЦГ 2. Хан Хөхийн нуруу		ТХГ-ын МТ-ний хуулбар
		Ховд	3. Булган гол, Их Онгогийн БЦГ 4. Цамбагарав уулын БЦГ		
		Баян-Өлгий	5. Мөнххайрхан уулын БЦГ		

**ТХГН-ын ойн тогтвортой менежментийн суурь судалгаагаар бүрдүүлэх  
дэлгэрэнгүй мэдээллийн сан**

Хүснэгт 3

<b>№</b>		<b>Суурь судалгаагаар бүрдүүлэх дэлгэрэнгүй мэдээлэл</b>
<b>I. Ойн суурь мэдээлэл (газрын зураг)</b>		
1	Ойн сан, түүний төлөв байдал	А. талбай /бүрхэгдсэн, бүрхэгдээгүй (шатсан, мод бэлтгэсэн), хөнөөлт шавжид нэрвэгдсэн, модны төрлөөр/ В. нөөц /модны төрлөөр/ С.1 га-ийн үндсэн үзүүлэлтүүд,
2	Ойн бүрхэвчийн зураг /хиймэл дагуулын мэдээллээр баяжуулах – Landsat, Bingmap гэх мэт/	
3	Ойн экосистемийн олон янз байдал, тэдгээрийн түлхүүр зүйлийн тухай мэдээлэл	
<b>II. Ой хамгаалалт /2000 оноос хойш/</b>		
1	Түймрийн эрсдэлийн байдал	А. түймэрт өртсөн талбай В. түймрийн тоо С. түймрийн шалтгаан D. түймрээс урьдчилан сэргийлэх болон тэмцэж буй арга хэмжээ
2	Хөнөөлт шавжид нэрвэгдсэн байдал	А. нэрвэгдсэн талбай В. хөнөөл учруулагч зонхилогч шавжийн зүйл С. авсан тэмцлийн арга хэмжээ
<b>III. Ой ашиглалтын төлөв байдал</b>		
1	Кластерын ойн ашиглалтын байдал, чиг хандлага	А. арчилгаа хийсэн болон хийх шаардлагатай талбайн хэмжээ, байршил В. цэвэрлэгээ хийсэн болон хийх шаардлагатай талбайн хэмжээ, байршил, С. ашиглалтын хэлбэр, төрөл, D. зах зээлийн онцлог
2	Ойн дагалт баялаг	А. Самар, жимс В. бусад
3	Ашиглалтын менежментийн өнөөгийн байдалд дүгнэлт өгөх	
<b>IV. Ойн нөхөн сэргэлт</b>		
1	Байгалийн сэргэн ургалтын төлөв байдал	
2	Ойг зориудаар нөхөн сэргээхэд үзүүлж буй нөлөөлөл	А. Хүний нөлөө В. Малын нөлөө
<b>V. Ойн менежмент</b>		
1	Кластерын ойн менежментэд оролцогч талуудын тухай мэдээлэл	
2	Кластерын хамтын менежментэд ойн ангийн гүйцэтгэж буй үүрэг роль, нөлөөлөл	



3	Кластер дахь ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүд, ойн санг гэрээгээр эзэмшигчийн тоо, төрөл, гэрээгээр эзэмшиж буй ойн сангийн талбайн хэмжээ, байршил
4	Кластерын менежментэд ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд, ойн санг гэрээгээр эзэмшигчийн гүйцэтгэж буй үүрэг, нөлөөлөл, тулгамдсан асуудлууд

Хүснэгт 4

### Бүртгэлийн маягт

Хуудас

Аймаг, сум..... Хэсэглэл..... Бүлэг ялгарал.....

Солбицол..... Хуудасны тоо.....

Хатсан, унанги, хожуул R=6м

№	Модлог	Н	Д	Зэрэг	№	Модлог	Н	Д	Зэрэг	№	Модлог	Н	Д	Зэрэг

### Ургаа мод


№	Жишүүр тоо			Диаметр			Өндөр			Нас		
	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3

Хэв шинж..... Сэргэн ургалт 1 2 3.....


Зүг..... Налуу..... Сөөг 1 2 3 .....

Арга хэмжээ.....

Тэмдэглэл.....



Зураг 2. Цэгийг тодорхойлж тооллого хийх бүдүүвч



Зураг 3. Унангийг хэмжих бүдүүвч



Ойн тооллого хэмжилтэд ашиглах багаж хэрэгсэл









VERTEX модны өндөр хэмжигч



Буссоль



Газрын чиглэл налуу хэмжигч

	
<p>Диаметр хэмжигч</p>	<p>Хөндлөн огтлолын талбай хэмжих</p>
	
<p>Мод тэмдэглэгч</p>	<p>Өсвөр мод хэмжих метр</p>
	
<p>Хэмжих ац</p>	<p>Зай хэмжих метр – 20м</p>

Зураг 4. Ойд хэмжилт хийх багажны бүрдэл

**Зорилт-2.** Кластер бүс нутаг тус бүрийн ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтийг тодорхойлох аргазүй:

Кластер нутгийн ойн тогтвортой менежментийн суурь үзүүлэлтийг “ойн экологийн төлөв байдлын”, “эдийн засгийн”, “нийгмийн” гэсэн тогтвортой менежментийн тулгуур “3” үзүүлэлтээр гаргана.

### **2.1. Ойн экологийн төлөв байдлын шалгуур үзүүлэлт**

- Кластер бүс нутгийн хүлэмжийн хийн ялгарал,  $tCO_2e$  жил
- Кластер бүс нутгийн хүлэмжийн хийн шингээлт,
- Кластер нутгийн 1 га ойн өсөлт,
- Эзэмшилд байгаа ойн сангийн хэмжээ,
- Доройтсон ойн сангийн талбайн хэмжээ
- Сэргэн ургасан ойн талбайн хэмжээ
- Байгалийн сэргэн ургалтыг дэмжсэн талбайн хэмжээ /булгийн эхийг хамгаалах, өсвөр модыг хамгаалж хашаалах/

Кластер нутгийн төлөв байдлын шалгуур үзүүлэлтийг энэхүү аргачлалын 1 дэх хэсэгт тодорхойлсон ойн сангийн суурь үзүүлэлтэд үндэслэн тооцооны аргаар тодорхойлно.

### **2.2. Эдийн засгийн шалгуур үзүүлэлт**

- Кластер бүс нутгийн 1 га ойгоос ашиглаж буй нөөцийн хэмжээ:
- Ойн арчилгаа, цэвэрлэгээгээр бэлтгэж ашиглаж буй модны хэмжээ,  $m^3$
- Ойн дагалт баялгийн хэмжээ: тоо, нэр төрлөөр
- Кластер нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Ойн мэргэжлийн байгууллага, тоогоор
- Ойгоос хүртэж байгаа үр ашиг /дагалт баялаг, эмийн ургамлын орлого, аялал жуулчлал, амралт, рашаан сувилал, модон бүтээгдэхүүн/
- Кластер нутагт ажиллаж байгаа жижиг, дунд үйлдвэр

Кластер нутгийн ойн “эдийн засгийн шалгуур үзүүлэлт”- ийг статистикийн түүвэр судалгааны аргаар гүйцэтгэнэ.

### **2.3. Нийгмийн шалгуур үзүүлэлт**

- Кластер нутгийн ойд ажиллаж байгаа ажлын байрны тоо
- Кластер нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Ойн нөхөрлөлийн гишүүдийн тоо
- Кластер нутагт амьдарч байгаа айл өрхийн тоо, амьжиргааны эх үүсвэр, түвшин

Кластер нутгийн ойн “нийгмийн шалгуур үзүүлэлт”-г асуумж судалгаа”- ны аргаар тодорхойлно.

Кластерт хамрагдаж байгаа сум тус бүрт ойн тогтвортой менежментийн нарийвчилсан судалгааг газар дээр нь очиж гүйцэтгэнэ.

**Зорилт-3.** Ойн бүрхэвчийн зураг болон нэн ховор, ховор, унаган ургамал, амьтны тархалтын зураглал, хамгаалах зөвлөмж боловсруулах арга зүй:

- 3.1. Кластер нутгийн ойн зураглалын ажлыг газарзүйн мэдээллийн системийн программ хангамж /ArcGIS, QGIS/ ашиглан боловсруулна. Ойн зураг боловсруулах ажилд Засгийн газрын 2009.01.28 өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан UTM/WGS-84 солбицлыг ашиглана. Ойн зураглалын ажилд суурь зураг болгон 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг болон 10м-ийн ялгах чадвартай Sentinel, 30м-ийн ялгах чадвартай Landsat зэрэг хиймэл дагуулын мэдээ ашиглана. Шаардлагатай тохиолдолд Google Earth, Bingmap ашиглана.
- 3.2. Кластер нутгийн нэн ховор, ховор, унаган ургамлыг тодорхойлох, зураглах, хамгаалах зөвлөмж боловсруулах  
Тус бүс нутагт өмнө хийгдсэн судалгааны материал болон мэдээ цуглуулж нэн ховор, ховор, унаган ургамлын нэр төрөл, тархалтыг тодорхойлно. Орон нутагт хэлэлцүүлэг хийхдээ оролцооны аргаар зураглуулна.
- 3.3. Кластер нутгийн нэн ховор, ховор, унаган ургамлыг тодорхойлох, амьтны тархалтыг зураглах, хамгаалах зөвлөмж боловсруулах  
Тус бүс нутагт өмнө хийгдсэн судалгааны материал болон мэдээ цуглуулж нэн ховор, ховор, унаган ургамал, амьтны нэр төрөл, тархац нутгийг тодорхойлно. Орон нутагт хэлэлцүүлэг хийхдээ оролцооны аргаар зураглал үйлдэнэ.

**Зорилт-4.** Кластерийн ой ашиглалтын төлөв байдалтай уялдуулж нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор тухайн бүс нутгийн ойн сангийн нөөц, өнөөгийн төлөв байдалд тулгуурлан ойн дагалт баялаг, мод, модлог нөөцийг ашиглан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр зөвлөмж боловсруулах;

- 4.1. Энэ хэсгийн ажлыг үндсэн арга зүй нь SWOT шинжилгээний арга байна. SWOT шинжилгээнд дор дурдсан үйл ажиллагааг хамруулна:
  - Ойн дагалт баялаг (самар, жимс, мөөг, эмийн ургамал бусад), түүний төрөл, тархалт, нөөц, ашиглалтын төлөв байдалд дүгнэлт өгөх
  - Кластерийн ойн менежментэд оролцогч талуудын тухай мэдээлэл
  - ТХГН-ууд, тэдгээрийн орчны бүсүүд болон экологийн холбоос газарт нутаглаж байгаа ард иргэдээс ойгоос орон нутаг, өрхийн амьжиргаанд оруулах орлого, үр ашиг болон бусад нийгэм, эдийн засгийн талаар мэдээлэл (судалгаа авах) цуглуулах.

4.2. Оролцооны аргаар сонгон авсан амьжиргааг дэмжих арга хэмжээг баталгаажуулна:

- Тухайн газар нутгийн ойн зураглал боловсруулсны үндсэн дээр төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, орон нутгийн ард иргэд, ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага болон бусад олон талын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах
- Ойн төлөв байдал, ойгоос хүртэх үр ашиг, ойд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар хэлэлцэж санал авах, орон зайн хувьд хаана байгааг тодорхойлон эрэмбэлж оролцооны аргаар зураглана.
- Оролцооны аргаар тодорхойлсон арга хэмжээг үндэслэн ойн дагалт баялаг, мод боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой зөвлөмж боловсруулна.





Хүснэгт 4

..... дүгээр кластер нутгийн ТХГ-ын болон түүний орчны бүсэд  
 хамаарах..... суманд ойрын /ОМТ-ний хугацаанд/ 4 жилд Ойн ашиглалтын  
 ажил явуулах газрын байршлын санал

Д/д	Ойн ашиглалт явуулах хэлбэр	Мод бэлтгэл явуулах				Мод бэлтгэл явуулах шалтгаан
		Газрын нэр	Ойн сангийн хэсэглэл, ялгарал	Он	Хэмжээ, шоо метр	

Хүснэгт 5

..... дүгээр кластер нутгийн ТХГ-ын болон түүний орчны бүсэд хамаарах  
 ..... сумын хэмжээнд Ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр  
 хэрэгжүүлэх төслийн санал

Д/д	Хэрэгжүүлэх төслийн нэр	Төслөөр гарах үр дүн	Шаардлагатай хөрөнгө, сая төг	Шинээр ажилтай болох хүний тоо	Кластерийн хэрэгжилтэнд оруулах хувь нэмэр

Хүснэгт 6

..... дүгээр кластер нутгийн ТХГ-ын болон түүний орчны бүсэд хамаарах  
 ..... сумын мод, модон материалын хэрэгцээ

Д/д	Мод, модон материалын нэр, төрөл	Хэмжээ, мян.шоо метр	Мод, модон материалын зориулалт	Шинээр ажилтай болох хүний тоо	Кластерийн хэрэгжилтэнд оруулах хувь нэмэр

### Хавсралт 3. Судалгаанд санал өгсөн оролцогчдын нэр

	Уулзалт, ярилцлага хийсэн хүмүүс	Байгууллага, Албан тушаал
1	Б.Бөхболд	Ховд аймгийн БОАЖГ-ын ой хариуцсан мэргэжилтэн
2	Э.Хосбаяр	Ховд аймгийн сум дундын ойн ангийн мэргэжилтэн
3	Б.Дэлгэрмаа	БОАЖЯ-ны төсөл хэрэгжүүлэх нэгжийн Ховд аймаг дахь орон нутаг хариуцсан мэрэгжилтэн
4	Мөнхдорж	БОАЖЯ-ны төсөл хэрэгжүүлэх нэгжийн Увс аймаг дахь орон нутаг хариуцсан мэрэгжилтэн
5	Буянцог	Увс аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн
6	Гэрэлээ	Увс аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн
7	Жамсран	Увс нуурын ай савын дархан цаазат газар ахлах мэргэжилтэн
Ховд аймаг булган сум		
8	Ж.Дамдинбазар	Засаг дарга
9	Ц.Сонгууль	ЗДТГ-ын дарга
10	Мөнхтөр	ЗД-ын орлогч
11	Гансүх	Баягаль орчны улсын байцаагч
12	Эрдэнэсүрэн	Байгаль хамгаалагч
13	Мөнхбаатар	Мөнххайрхан уулын БЦГ-ын байгаль хамгаалагч
14	Б.Батзориг	Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны газрын дарга
Баян-Өлгий аймгийн Булган сум		
15	Ерболат	Засаг дарга
16	Баасанжав	Мөнххайрхан уулын БЦГ-ын байгаль хамгаалагч
17		Баягаль орчны улсын байцаагч
18		Байгаль хамгаалагч
19	М.Одхүү	Мөнххайрхан уулын УТХГНХЗ-ны дарга
20		Мөнххайрхан уулын БЦГ-ын байгаль хамгаалагч
Ховд аймаг Эрдэнэбүрэн сум		
21	Цэвэлмаа	Засаг даргын тамгийн газрын дарга
22	Даваацэрэн	Сумын байгаль хамгаалагч
23	Батмөнх	ТХГ-ын байгаль хамгаалагч
Ховд аймаг Мянгад сум		
24	Н.Баатар	Засаг дарга
25	Д.Баатарсүрэн	ИХДарга
26	Д.Нямбаяр	ЗД-ын орлогч
27	Хишигтогтох	Сумын байгаль орчны байцаагч
28	Д.Доржсүрэн	Сумын байгаль хамгаалагч
Увс аймаг Зүүнхангай сум		
29	Цэрэндорж	ЗДТГ-ын дарга

30	Нямбар	Сумын байгаль орчны байцаагч
31	Жаргалсайхан	ТХГН-ын байгаль хамгаалагч
Увс аймаг Өндөрхангай сум		
32	Г.Төмөрчөдөр	Засаг дарга
33	Цэлмэгдалай	Хан Хөхий нурууний ТХГН-ийн дарга
34	Ж.Басбаяр	ТХГН-ийн мэргэжилтэн
35	Д.Эрдэнэцэцэг	Байгаль хамгаалагч
Увс аймаг Цагаанхайрхан сум		
36	Төөрүүл	ЗДарга
37	Дорж	ЗД-ын орлогч
38	Шинэбаяр	ИТХ-ын дарга
39	Хуягаа	Сумын байгаль хамгаалагч
40	Хишигбаяр	ТХГН-ийн байгаль хамгаалагч
Увс аймаг Түргэн сум		
41	С.Давааням	Тамгийн газрын дарга
42	Баяраа	Байгаль орчны улсын байцаагч
43		Газрын даамал
44	Дээшин	Сум дундын ойн ангийн дарга